МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2021 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ ХУУЛЬ ЗҮЙН БОЛОН ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 09-НИЙ ӨДӨР /МЯГМАР ГАРАГ/-ИЙН ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ ТОВЬЁГ

№	Баримтын агуулга	Хуудас
1.	**Хуралдааны товч тэмдэглэл:**	1-23
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл	24-105
	1.Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.05.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, **анхны хэлэлцүүлэг**, үргэлжилнэ/	26-74
	2. Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.05.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, **анхны хэлэлцүүлэг**/	74-105

Монгол Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганы Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хорооны 11 дүгээр сарын 09-ний өдөр /Мягмар гараг/-ийн хамтарсан хуралдааны товч тэмдэглэл

Хууль зүйн байнгын хорооны дарга С.Бямбацогт ирц, хэлэлцэх асуудлын дараалыг танилцуулж, хамтарсан хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 51.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 30 минутад Төрийн ордны "Их эзэн Чингис хаан" танхимд эхлэв.

Чөлөөтэй: Э.Бат-Амгалан, Ц.Идэрбат, Б.Энхбаяр;
Эмнэлгийн чөлөөтэй: Н.Ганибал, Х.Ганхуяг, Т.Доржханд, Б.Дэлгэрсайхан, Ж.Чинбүрэн.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга Д.Ганбат "Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай" хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан Ардчилсан намын бүлгээс авсан завсарлагын хугацаа дуусан талаар мэдэгдэв./09:35/

Нэг.Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд */Засгийн газар 2021.05.19-ний өдөр өргөн мэдүүлсэн,* ***анхны хэлэлцүүлэг****, үргэлжилнэ/*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг, мөн газрын ахлах мэргэжилтэн Ж.Амгалан, шинжээч Х.Сүрэнхорол, Мэдээллийн технологийн газрын дарга Д.Ган-Эрдэнэ, Тагнуулын ерөнхий газрын Мэдээллийн аюулгүй байдлын газрын дарга Э.Эрдэнэ, мөн газрын Мэдээллийн аюулгүй байдлын албаны дарга Д.Ганзориг, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Болор-Эрдэнэ, мөн газрын Мэдээллийн технологийн бодлого зохицуулалтын газрын дарга Б.Билэгдэмбэрэл, Цахим хөгжлийн үндэсний хорооны Ажлын албаны дарга С.Тэнгис, Мэдээллийн холбооны операторуудын ассоциацын гүйцэтгэх захирал У.Тамир нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх П.Батбаатар, референт Б.Золбоо, Хууль зүйн байнгын хороо хариуцсан референт Л.Мөнхчимэг, гэрээт ажилтан Б.Галсанбат, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн Ажлын албаны ахлах референт Д.Ядамжав нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Төслийн 5, 6, 7, 10, 11, 13, 14, 15, 16, 17, 19, 23, 24, 25, 26, 28, 29, 30, 31 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс санал гараагүй болно.

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтын “мэдээлэл хамгаалахад” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 7
Бүгд: 19
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтын “утга зохиолын бүтээл туурвих,” гэсний дараа “нээлттэй өгөгдөл,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 5
Бүгд: 18
72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 8 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд, Ж.Сүхбаатар, Ц.Сандаг-Очир нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал хариулж, тайлбар хийв.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн “хуульд зааснаас бусад тохиолдолд” гэсний дараа “мэдээллийг боловсруулах, цуглуулах, ашиглахдаа” гэж, 8.2.3 дахь заалтын “боловсруулах,” гэсний өмнө “цуглуулах,” гэж тус тус нэмж, 8.2.6 дахь заалтын “мэдээллийн төрөл, агуулга” гэснийг “мэдээллийн жагсаалт” гэж, 8.2.7 дахь заалтын “цуцлах нөхцөл” гэснийг “цуцлах хэлбэр” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 5

Бүгд: 18
72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 9 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж нар хариулж, тайлбар хийв.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.1.Энэ хуулийн 4.1.2-т заасан эрүүл мэнд, захидал харилцаа, генетик, биометрик, тоон гарын үсгийн хувийн түлхүүр, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, бэлгийн харьцааны талаарх хүний эмзэг мэдээлэл нь хувь хүний нууцад хамаарна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 4
Бүгд: 17
76.5 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалтын “эрүү, иргэн, захиргааны болон бусад” гэснийг, 10.2 дахь хэсгийн “Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэн тогтоосон” гэснийг тус тус хасч, 10.2 дахь хэсгийн “ажилтны” гэсний дараа “зөвшөөрлөөр” гэж нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 10.1.5 дахь заалт нэмэх:

“10.1.5.Монгол Улсын Их Хурлын гишүүн хуралдааны ирцэд бүртгүүлэх, санал хураалт явуулах зорилгоор хүний биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/-ийг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 3
Бүгд: 17
82.4 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсгийн “Энэ хуулийн 11.1, 11.3-т заасан зорилгоор” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 3
Бүгд: 17
82.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 12 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг хариулж, тайлбар хийв.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “мэдээллийн эзний зөвшөөрлөөр” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 3
Бүгд: 17
82.4 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь заалтын “бэлгийн чиг хандлага,” гэснийг “бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл,” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 4
Бүгд: 17
76.5 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “цуглуулж, боловсруулж, ашиглаж байгаа” гэснийг хасч, 15.1.3 дахь заалтын “цуглуулснаас” гэснийг “цуглуулж, боловсруулснаас” гэж, “эсхүл гэрээнд заасан,” гэснийг “гэрээнд заасан, эсхүл харилцан тохиролцсон” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 3
Бүгд: 17
82.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 18 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэдийн тавьсан асуултад ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг нар хариулж, тайлбар хийв.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийн “мэдээллийн ангилал” гэснийг “мэдээллийн жагсаалт,” гэж, 19.4.7 дахь заалтын “мэдээлэл хариуцагчийн өгсөн үүрэг, зааврыг” гэснийг “мэдээлэл хариуцагчийн өгсөн үүрэг, чиглэл, даалгаврыг” гэж тус тус өөрчилж, 19.3 дахь хэсгийн “шилжүүлсэн тохиолдолд мэдээлэл боловсруулагчид хүлээлгэх” гэснийг, 19.4.2 дахь заалтын “мэдээллийн эзний” гэснийг, 19.4.4 дэх заалтын “буцааж” гэснийг болон 19.6 дахь хэсгийг тус тус хасч, 19.4.6 дахь заалтын “энэ хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу” гэсний дараа “мэдээллийн” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 20 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал хариулж, тайлбар хийв.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийн гарчгийн “Аюулгүй байдлыг” гэсний өмнө “Мэдээллийн” гэж, 20.1.1 дэх заалтын “мэдээллийн аюулгүй

байдлыг хангах” гэсний өмнө “энэ хуулийн 20.2-т заасан шаардлагад нийцүүлэн” гэж тус тус нэмж, 20.1 дэх хэсгийн “чиглэлээр зохион байгуулалтын болон техникийн” гэснийг “талаар” гэж, 20.1.4 дэх заалтын “мэдээллийг тодорхойлох боломжгүй болгох талаар тодорхой” гэснийг “мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй болгох талаар” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн “харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэснийг “цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж тохиолдол бүрд агуулгад нь тохируулан өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 5
Бүгд: 17
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 21 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж нар хариулж, тайлбар хийв.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1.2 дахь заалтын “мэдээллийг” гэсний өмнө “боловсруулсан” гэж нэмж, 21.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.2.Мэдээлэл хариуцагч энэ хуулийн 21.1-д зааснаас бусад тохиолдолд мэдээллийн эзний мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглахад мэдэгдэл хүргүүлж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 4
Бүгд: 15
73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 22 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан үг хэлэв.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 22 дугаар зүйлийн 22.6 дахь хэсгийн “бүртгэлийг жил бүр” гэснийг “бүртгэлийг жил бүрийн 01 дүгээр сард” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 4
Бүгд: 15
73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1.2 дахь заалтыг хасч, 24.1.4 дэх заалтын “хууль, эрх зүйн туслалцаа үзүүлэх” гэснийг “шаардлага, зөвлөмж өгөх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 4
Бүгд: 15
73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 27 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Б.Энх-Амгалан нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал, ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж нар хариулж, тайлбар хийв.

Хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсгийн “дүрс бичлэгийн” гэснийг, 27.9 дэх хэсгийн “хандаж харах,” гэснийг болон 27.11 дэх хэсгийг тус тус хасч, 27.4.3 дахь заалтын “нийтийн зориулалттай орон сууцны” гэсний дараа “орох, гарах нийтийн хэсэг болон дундын эзэмшлийн талбайн” гэж нэмж, 27.4.1 дэх заалтын “караоке” гэснийг “караокены өрөө,” гэж, 27.4.3 дахь заалтын “дүрст хэлбэрээр түгээх” гэснийг “дүрст хэлбэрээр тараах” гэж, 27.7 дахь хэсгийн “бичлэгийн системд” гэснийг “бичлэгийн төхөөрөмж байршуулахад” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 27.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 27.2 дахь хэсэг болгох:

“27.2.Дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн систем нь энэ хуулийн 27.1-д заасан төхөөрөмж, мэдээлэл дамжуулах сүлжээ, хадгалах төхөөрөмж, программ хангамжаас бүрдэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 5
Бүгд: 16
68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 4
Бүгд: 16
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 32 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар үг хэлэв.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийн “2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс” гэснийг “2022 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 6
Бүгд: 15
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, бүлэг, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 4
Бүгд: 15
73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал:

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.6 дахь заалтын “хөндөөгүй тохиолдолд” гэснийг “хөндөхгүйгээр” гэж, төслийн “дүрс бичлэг” гэснийг “дүрсний бичлэг” гэж тохиолдол бүрд агуулгад нь тохируулан тус тус өөрчлөх.

2.Төслийн 23 дугаар зүйлийн 23.1.1 дэх заалтын “мэдээлэлд хүний оролцоогүй цахим хэлбэрээр хийх боловсруулалт нь” гэснийг хасах.

3.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтыг доор дурдсанаар 5.1.1, 5.1.2 дахь заалт болгох:

“5.1.1.хүний эрх, эрх чөлөөг зөрчихгүй байх;
5.1.2.хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 4
Бүгд: 15
73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс санал гараагүй болно.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Байгууллагын нуцын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл, Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Гамшгаас хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1, 2 дугаар зүйл, Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Жендэрийн эрх, тэгш байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Захиргааны ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2, 3 дугаар зүйл, Зээлийн мэдээллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Инновацын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай төслийн 1, 2 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл, Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Нотариатын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Өмгөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2, 3 дугаар зүйл, Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Статистикийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2, 3 дугаар зүйл, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Тагнуулын байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Төрийн бус байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Улсын бүртгэлийн ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Үндэсний

аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Хүүхдийн эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Шүүхийн шинжилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2, 3 дугаар зүйл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс санал гараагүй болно.

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн “12.1, 12.3 дахь хэсгийн “Хувь хүний нууцын тухай” гэснийг “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай” гэж,” гэснийг “12.1 дэх хэсгийн “хувь хүний нууцад хамаарах бөгөөд түүнтэй холбогдох асуудлыг Хувь хүний нууцын тухай” гэснийг “хүний хувийн мэдээлэлд хамаарах бөгөөд түүнтэй холбогдох асуудлыг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай” гэж, 12.3 дахь хэсгийн “Хувь хүний нууцын тухай” гэснийг “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай” гэж” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 5
Бүгд: 15
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байгууллагын нууцын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуягийн тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар хариулж, тайлбар хийв.

2.Ажлын хэсгийн гаргасан, Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн “Гаалийн тухай хуулийн” гэсний дараа “5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсгийн “төр, хувь хүний, байгууллагын нууцад хамаарах мэдээллийг” гэснийг “төрийн болон албаны, байгууллагын нууц, хүний хувийн мэдээллийг” гэж, “нууцын хууль тогтоомжоор” гэснийг “холбогдох хууль тогтоомжоор” гэж,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 6
Бүгд: 15
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн “хүний эмзэг мэдээллийг” гэснийг “хүний хувийн мэдээллийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 6
Бүгд: 15
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 101 дүгээр зүйлийн 101.2 дахь хэсгийн “төр, байгууллага, хувь хүний нууцтай” гэснийг “төрийн болон албаны, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлтэй” гэж” гэсний дараа “, “Захидал харилцааны нууцыг” гэснийг “Захидал харилцааны мэдээллийг” гэж” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 4
Бүгд: 15
73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 6.22 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийн “дүрсний, дуу-дүрсний” гэсний өмнө “дууны,” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 5
Бүгд: 15
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 6.22 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “орон байранд” гэснийг “нийтийн зориулалттай орон сууцанд оршин сууж байгаа” гэж, 1 дэх заалтын Тайлбар хэсгийн “караоке” гэснийг “караокены өрөө,” гэж, 2 дахь заалтын 6.27 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “мэдээллийн эзний эрх, эрх чөлөөг хөндөж” гэснийг “мэдээллийн эзний эрх, эрх чөлөөг зөрчиж,” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 5
Бүгд: 15
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 6.22 дугаар зүйлийн Тайлбар хэсгийн “цахилгаан шат” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 6
Бүгд: 15

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 6.27 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 7
Бүгд: 15
53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх:

"**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө." гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 5
Бүгд: 15
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн "38 дугаар зүйлийн 38.6 дахь хэсэг, 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг," гэснийг "38 дугаар зүйлийн 38.6 дахь хэсгийн "төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой" гэснийг "төрийн болон албаны, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлтэй холбоотой" гэж, 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийн "төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотойгоос" гэснийг "төрийн болон албаны, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлтэй холбоотойгоос" гэж," гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 3
Бүгд: 15
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 33 дугаар зүйлийн 33.4 дэх хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.5 дахь хэсэг, 77 дугаар зүйлийн 77.1.4, 77.5.1, 77.12.4 дэх заалтын "хувь хүний нууцад" гэснийг "хүний эмзэг мэдээлэлд" гэж," гэсний дараа "49 дүгээр зүйлийн 49.2.6 дахь заалтын "захидал харилцааны нууц" гэснийг "захидал харилцааны мэдээлэл" гэж," гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 4
Бүгд: 15
73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн “12 дугаар зүйлийн 12.5 дахь хэсгийн “төрийн болон албаны, байгууллага, хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцад” гэснийг, мөн зүйлийн” гэснийг “12 дугаар зүйлийн 12.5 дахь хэсгийн “төрийн болон албаны, байгууллага, хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцад” гэснийг “Төрийн болон албаны, Байгууллагын нууцын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиар хамгаалагдсан нууц, хүний хувийн мэдээлэлд” гэж, “111 дүгээр зүйлийн 111.6 дахь хэсгийн “төрийн болон албаны, байгууллага, хувь хүний нууцад” гэснийг “байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлд” гэж” гэснийг “111 дүгээр зүйлийн 111.6 дахь хэсгийн “төрийн болон албаны, байгууллага, хувь хүний нууцад” гэснийг “төрийн болон албаны, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлд” гэж” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 4
Бүгд: 15
73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга С.Бямбацогт хариулж, тайлбар хийв.

Хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

13.Ажлын хэсгийн гаргасан, Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн “Прокурорын тухай хуулийн 58 дугаар зүйлийн” гэсний дараа “58.3 дахь хэсгийн “захидал, харилцаа, хувийн нууц,” гэснийг “хүний эмзэг мэдээлэл,” гэж,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 4
Бүгд: 15
73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“**1 дүгээр зүйл**.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах заалтыг нэмсүгэй:

1/7 дугаар зүйлийн 7.1.10 дахь заалт:

“7.1.10.Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 3

Бүгд: 15
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийн “байна.” гэснийг “байх бөгөөд хүний хувийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах, хамгаалах үйл ажиллагаанд хяналт тавих нэгжтэй байна.” гэж, гэсний дараа “39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсгийн “захидал харилцааны нууцыг” гэснийг “захидал харилцааны мэдээллийг” гэж” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 5
Бүгд: 15
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн “хүний эмзэг мэдээллийг” гэснийг “хүний хувийн мэдээллийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 4
Бүгд: 15
73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Хүүхдийн эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн “Хүүхдийн эрхийн тухай хуулийн” гэсний дараа “7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн “эрүүл мэнд, хувийн харилцааны нууц,” гэснийг “хувийн мэдээлэл,” гэж,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 6
Бүгд: 15
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Хүүхдийн эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн “эмзэг мэдээллийг” гэснийг “хувийн мэдээллийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 7
Бүгд: 15
53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг хариулж, тайлбар хийв.

19.Ажлын хэсгийн гаргасан, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн “цахилгаан шат” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 7
Бүгд: 15
53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлийн “дүрсний, дуу-дүрсний бичлэг” гэсний өмнө “дууны,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 5
Бүгд: 15
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлийн “цахим гарын үсэг, бэлгийн чиг хандлага,” гэснийг “тоон гарын үсгийн хувийн түлхүүр, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл,” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 7
Бүгд: 15
53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн” гэсний дараа “1.11 дүгээр зүйлийн гарчиг, уг зүйлийн 1 дэх хэсгийн ““захидал харилцааны нууцыг” гэснийг “захидал харилцааны мэдээллийг” гэж,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 6
Бүгд: 15
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 59 минутад хэлэлцэж дуусав.

Дэлгэрэнгүй тэмдэглэл

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулъя.

Ардчилсан намын бүлгийн завсарлагын хугацаа дууссан. Сая Ганбат дарга хэллээ.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Баасандорж Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Сайнзориг Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Ган-Эрдэнэ Хууль зүй, дотоод хэргийн яамны Мэдээллийн технологийн газрын дарга, Болор-Эрдэнэ Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга, Нямдаваа ЦЕГ-ын Хуулийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа, Эрдэнэ Тагнуулын ерөнхий газрын Мэдээллийн аюулгүй байдлын газрын дарга, Ганзориг Тагнуулын ерөнхий газрын Мэдээллийн аюулгүй байдлын албаны дарга, Бидэгдэмбэрэл Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын Мэдээллийн технологийн бодлого, зохицуулалтын газрын дарга, Тэнгис Цахим хөгжлийн үндэсний хорооны Ажлын албаны дарга, Амгалан Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах мэргэжилтэн, Сүрэнхорол Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын шинжээч, Тамир Мэдээллийн холбооны операторуудын ассоциац. Ийм хүмүүс оролцож байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-т Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

14 хоногийн өмнө хэлэлцээд явж байсан. Завсарлага авсан. 5 дугаар зүйл дээр зогссон байгаа. Одоо 5 дугаар зүйлээс эхэлнэ ээ.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна.

Санал хураалт явуулъя.

5 дугаар зүйл дээр буюу гишүүдэд тарааж өгсөн материалын зарчмын 3 дахь буюу 5 дугаар зүйл дээр ажлын хэсгээс санал гарсан байна. Уншиж танилцуулъя.

Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтын “мэдээлэл хамгаалахад” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Нямбаатар гишүүн, Сүхбаатар гишүүн хуралдаандаа хүрэлцэн ирсэн байна.

Санал хураалтад 17 гишүүн оролцож, 63,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна. 5 дугаар зүйл дээр.

Хуулийн төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гаргаагүй байна. Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Ажлын хэсгээс санал байна.

Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтын “утга зохиолын бүтээл туурвих,” гэсний дараа “нээлттэй өгөгдөл,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

72,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гишүүдээс 7 дугаар зүйлтэй холбогдуулан 6 дугаар зүйлтэй тийм ээ, санал алга байна.

Хуулийн төслийн 8 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Раднаасэд гишүүн асуултаа асууя. Сүхбаатар гишүүн.

Ш.Раднаасэд: Мэдээллийн эзнээс зөвшөөрөл авах гээд энэ дээр чинь хэвлэлийнхэн, энэ олон нийтийн бас нэг гол бухимдал дагуулаад байгаа зүйл шүү дээ. Хайрцаг, хүрээг ялангуяа одоо энд бас хэвлэлийнхэн үзэж харж байгаа байх. Үүнийг Учрал гишүүн ээ, яг ийм ийм хүрээнд зөвшөөрөл явагдах юм аа. Зөвшөөрөл явуулаагүйгээс болж ямар зөвшөөрөл аваагүйгээс болж ямар хор уршиг эрсдэл үүсэх юм бэ. Энэ эрсдэлийг хаахын тулд Байнгын хороодын гишүүдэд ч гэсэн сайн өгөх хэрэгтэй байгаа юм.

2 дугаарт, энэ дотроо бас нэг асуух гээд байгаа гол зүйл бол энэ дотор улс төрчдийн гэдэг юм уу хүний хөрөнгө орлоготой холбоотой нөгөө эмзэг мэдээлэл гээд яваад байгаа шүү дээ. Энэ дотор чинь энэ чинь хамаарахгүй байгаа биз дээ. Тэртэй тэргүй Улсын Их Хурлын гишүүд, төрийн өндөр албан тушаалтнуудын хөрөнгө орлогын мэдүүлэг ил байгаа. Гаргаж байгаа бүх түвшний төрийн байгууллагын албан тушаалтны нууцад хамаарахаас бүх шийдвэр ил байгаа. Ялангуяа энэ худалдан авах ажиллагаа, сонгон шалгаруулалт, тендер бүх зүйлтэй холбоотой. Энэ зүйлүүдийг мэдээлэхэд заавал зөвшөөрөл явах ёстой гэдэг ийм байдал цаашаа явчих вий. Тэгээд үүний үргэлжлэл чинь хойноо тэр 16 дугаар зүйл дээр бил үү гарч ирж байсан. Аюулгүй байдлын журмыг байгууллага өөрөө тогтоохоор, мэдээллийнхээ. Тэр зүйл дээрээ энэ чинь очиж наалдах юм бол ерөөсөө тухайн байгууллагын удирдлага өөрт хамаарах бүх мэдээллийг аюулгүй байдлын үүднээс хамгаалж байна гээд хаачих, боочих ийм нөхцөлд аваачаад оруулчхаж байгаа юм. Нөгөө мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах гэсэн төрийн чинь үндсэн зарчим нь энэ хуулиар чинь хаагдчих вий гэсэн болгоомжлол байгаа байхгүй юу.

Энэ дээр тодорхой хариултуудыг авъя гэж. Ийм 2 асуулт байна.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын даргын захирамжаар Нийтийн мэдээллийн тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Кибер аюулгүй байдлын тухай, Цахим гарын үсгийн тухай хуулийн төслүүдийн хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан байгаа. Улсын Их Хурлын гишүүн, Инновац, цахим

бодлогын байнгын хорооны дарга Учрал гишүүн ахалж байгаа. Гишүүдээр Алтанхуяг гишүүн, Анужин гишүүн, Бат-Амгалан гишүүн, Доржханд гишүүн, Мөнхбаатар гишүүн, Саранчимэг гишүүн, Сүхбаатар гишүүн, Цогтбаатар гишүүд ажиллаж байгаа.

Ингээд ажлын хэсгийн ахлагч Учрал гишүүн асуултад хариулъя.

Н.Учрал: Хүний хувийн мэдээлэл хамгаалах хууль дээр анх хэлэлцэж эхлэхээс нь авахуулаад сэтгүүлчид, 12 дугаар зүйлийн талаар нэлээдгүй олон асуултыг асуусан. Бид бол Засгийн газраас өргөн мэдүүлсэн хууль дээр ажлын хэсэг ажиллаад сэтгүүл зүйн зорилгоор мэдээллийн эзний зөвшөөрлөөр эсвэл нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үүднээс мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглаж болно гэдэг 12.1 дүгээр зүйлийг сэтгүүл зүйн зорилгоор нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үүднээс мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглаж болно гээд. Мэдээллийн эзний зөвшөөрлөөр гэдгийг энэ томьёоллыг хасахаар оруулж ирж байгаа. Ингээд хасчхаар сэтгүүл зүйн зорилгоор нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үүднээс юм уу эсвэл сэтгүүл зүйн зорилгоор мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглаж байгаа бол заавал мэдээллийн эзний зөвшөөрөл гэдэг зүйл шаардахгүй гэдэг ийм ойлголттой болж байгаа. Тэгэхээр энэ хуулийнхаа 29 дүгээр зүйлийн хориглох зүйл дээр мөн өнөөдөр ажлын хэсгээс 29.2, 29.3 буюу мэдээллийн эзний зөвшөөрөлгүй бусад эх сурвалжаас боловсруулж мэдээллийн эзнийг таньж тодорхойлох хориглоно гээд 29.2, 29.3 гэсэн хориглох зүйл дээр байгаа заалтыг мөн хасах саналтайгаар оруулж ирж байгаа. Тэгэхээр сэтгүүлч нар ямар нэгэн мэдээлэл бэлтгээд гаргахад заавал мэдээллийн эзний зөвшөөрлийг авах шаардлагагүй. Гэхдээ мэдээж эх сурвалж нь бол үнэн бодитой байх ёстой. Мэдээж гүтгэсэн, доромжилсон байгаа тохиолдолд бусад органик хуулиараа хариуцлага хүлээх зохицуулалт нь угаасаа одоо байгаа учраас.

Тэгэхээр ийм томьёоллыг хасчхаж байгаа учраас дахиж ийм асуудал үүсэхгүй гэдгийг бас хэлмээр байна. Мэдээж энэ Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуулийн гол зорилго бол мэдээллийг цуглуулж байгаа боловсруулж байгаа, ашиглаж байгаа тал бол мэдээлэл хариуцагч тал өөрөө үүрэг хүлээж байгаа учраас мэдээлэл хариуцагчийн талд үүрэг нь ноогдоно оо. Хэрвээ цуглуулж байгаа бол мэдээлэл хариуцаж байгаа тал үүнийг хадгалах, хамгаалах үүргийг давхар хүлээж байгаа юм.

Раднаасэд гишүүний 2 дахь асуулт буюу хөрөнгийн асуудал дээр бас ажлын хэсгээс тухайн хувь хүний хөрөнгийн талаарх мэдээллийг хүний эмзэг мэдээлэлд хамруулж байсан бол энэ улс төрийн өндөр албан тушаалтнууд болоод төрийн албан тушаалтнуудын хөрөнгө орлогын мэдүүлэг ил байгаа. Тэгэхээр үүнтэй холбогдуулаад хөрөнгийг эмзэг мэдээллээс хасаад хүний хувийн мэдээлэл рүү оруулахаар энэ ажлын хэсгээс санал орж ирж байгаа юм. Тэгэхээр ийм бас зөрчил үүсэхгүй. Хөрөнгийн мэдээлэл нь гарч ирнэ.

Үүний дараа Нийтийн мэдээллийн хуулийг хэлэлцэх үеэр бид нар 5 төрлийн 67 мэдээллийг нийтэд нээлттэй болгож байгаа. Үүн дотор худалдан авах ажиллагааны талаар, тендерийн оролцсон талаарх, тэр лиценз эзэмшиж байгаа иргэдийн талаарх мэдээллүүд мөн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, газар эзэмшиж байгаа мөн, тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа иргэдийн мэдээ, мэдээллийг бол нээлттэй болгоно. Гэхдээ түүнийг нээлттэй болгох үүргийг мэдээлэл цуглуулж байгаа тал буюу тэр тухайн төрийн байгууллага нь олон нийтэд нээлттэйгээр ийм мэдээлэл өгөх үүргийг хүлээж байгаа. Мэдээллээ вэб

хуудсаар, сонин хэвлэлээр, зар самбараар ямар нэгэн хэлбэр гаргаж болно. Тэгэхээр нөгөө бүртгэлийн хууль баталсантай холбогдуулаад open data гээд вэб хуудас гараад компаниудын мэдээлэл эзэмшигчтэйгээ ил болсон шиг энэ хуулиар 67 мэдээллийг нээлттэй болгож өгч байгаа. Тэгэхээр үүн дотор тэр улс төрийн өндөр албан тушаалтнуудтай холбоотой хөрөнгө орлогынх нь мэдүүлэг, тэр лиценз эзэмшиж байгаа бол баялгийн санд төвлөрүүлж байгаа орлого, зарлага бүх мэдээллүүд бол тэр 67 мэдээлэл дотор нээлттэй болно. Тэгэхээр хөрөнгийн талаарх мэдээллээ … /минут дуусав/

С.Бямбацогт: Сүхбаатар гишүүн асуултаа асууя.

Ж.Сүхбаатар: Сая Раднаасэд гишүүн үндсэндээ л агуулга давхацчихлаа. Зүгээр би өөрөө ажлын хэсэгт байгаа. Гэхдээ сүүлд хуралдаанд үнэхээр сууж чадаагүй. Хяналт шалгалтын хуулийн ажлын хэсгийг ахалж байгаа учраас давхцаад байна л даа. Манай энэ юунууд.

Зүгээр анхаарах юм бол сая нэмээд юун дээр анхааруулах юм бол энэ хууль бол Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль. Тэгэхээр сэтгүүлчид бас зөв зүйтэй ойлгох ёстой. Энэ бол нийтийн мэдээллийн тухай асуудал яригдаж байгаа биш. Саяны тэр 8 дугаар зүйлийн мэдээллийн эзнээс зөвшөөрөл авахыг зарим нь буруу ойлгоод энэ заалтыг мушгиад байна лээ. Тэр бол тийм биш л дээ. Энэ бол хувь хүний. Харин тэр Нийтийн мэдээллийн хууль дээрээ их анхаарал хандуулах ёстой л юм байгаа юм. Ер нь бол хэвлэл мэдээллийнхэн.

Бид нарын гарчиг бас жоохон тийм л байгаа юм. Би өөрөө 10 жилийн өмнө энэ хуулийг Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуулийг батлуулж байсан учраас Байнгын хорооны дарга байхдаа. Энэ нэр нь бол жоохон сулруулчхаад байгаа байхгүй юу. Нийтийн мэдээлэл. Нийтийн мэдээлэл гэж байгаа бол нийтийн мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрх байхгүй юу. Хуулийн зорилгоо их тодорхой байлгах ёстой. Ер нь жоохон тийм шүүмжлэл өрнөчих гээд л. Ер нь гаднынхан чинь энэ хуулийг гараад ирэхээр яг бүх үзүүлэлтээр нь хянана л даа. Энэ бол Монгол Улсын жинхэнэ олон өрсөлдөх чадварын шалгуурууд дотор хүний эрх эд нартай холбоотой асуудлууд дээр энэ хууль бол өөрөө шалгуур болж орно. Энэ манай Их Хурлын хандлага бас энэ дээр харагдана. Тэгэхээр энэ дараагийн хууль дээрээ бид нар илүү анхаарах ёстой. Тэр хэвлэл мэдээллийнхнийг бол би тэр рү илүү анхаарах ёстой. Мэдээллийн ил тод байдал. Мэдээлэл авах эрх гэдэг тэр одоо явж байгаа хүчин төгөлдөр байгаа хуулийнхаа тэр юмыг дордуулахгүй байх хэрэгтэй. Тэр талаас нь хандах ёстой гэдгийг л би хэлэх гэсэн юм.

Түүнээс түрүүний асуух гэж байсан зүйлийг Раднаасэд гишүүн хэлчихсэн учраас би зүгээр санал, анхааруулга маягаар л хэлж байгаа юм.

С.Бямбацогт: Сүхбаатар гишүүн ажлын хэсгийн гишүүн байгаа. Бас тодруулж хариуллаа гэж ойлгоё.

Сандаг-Очир гишүүн асуултаа асууя.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Би 8.6 дээр тодруулъя. Мэдээлэл цуглуулах зөвшөөрөлд мэдээллийн эзэн хариу өгөөгүй бөгөөд ийнхүү хариу өгөхөөр тогтоосон хугацаа эсвэл ердийн боломжит хугацаа өнгөрсөн нь мэдээлэл цуглуулахыг зөвшөөрөн тооцох үндэслэл болохгүй гж байгаа байхгүй юу. Тэгээд

энэ заалт чинь үндсэндээ бараг энэ хуулийн чинь гол зорилгыг хаачхаж байгаа юм биш үү. Би таны талаар мэдээлэл цуглуулж байгаа юм аа. Ашигт малтмал, лиценз, уул уурхайтай холбоотой, оффшор данстай холбоотой ч гэдэг юм уу.

Тухайн эзнээс нь зөвшөөрөл хүсдэг. Гэтэл тэр хүн өөрийнхөө талаар ингээд мэдээж зөвшөөрөл өгөхгүй шүү дээ. Би өөрийгөө шалгуулъя гэдэг юм уу би энэ талаараа мэдээлэл. Тэгээд дуугүй байгаад байвал тэгээд тэр мэдээллийг тэр цуглуулж чадахгүй нь л дээ. Тэгэхээр үүнийг тодруулж өгөөч ээ. Үүнийг тодруулж асууя аа. Энэ заалт бол нэлээн л хатуу заалт байх юм. Цуглуулахыг зөвшөөрөх нь тооцох үндэслэл болохгүй гэж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ мэдээлэл ингээд хаалттай болчхож байгаа юм. Үүнээс цаашаа мэдээлэл цуглуулагч бол тэр талаар мэдээлэл авах, хөөцөлдөх, цуглуулах талаар хязгаартай болчхож байна гэсэн үг. Үүнийг тодруулж өгөөч.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн ахлагч, Учрал гишүүн хариулъя.

Н.Учрал: Энэ Нийтийн мэдээллийн хууль, Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хууль бол хоорондоо уялдаатай. Тэгэхээр тэр 67 мэдээлэл чинь нээлттэй. 5 мэдээллийг нь хязгаартай. Зарим мэдээллийг нь хаалттай гээд ингээд ангилчхаж байгаа юм. Тэгэхээр энэ хувь хүний мэдээлэл хамгаалах бол тэр нийтийн мэдээллээс өөр хууль. Жишээ нь, хувь хүний мэдээллийг янз бүрийн байдлаар ажил олгогч ч гэдэг юм уу ажилтнаасаа цуглуулж байлаа гэж бодоход хэрвээ тэр мэдээллийн эзэн нь өөрөө хариу өгөхгүй байгаа тохиолдолд хугацаа эсвэл ердийн боломжит хугацаа өнгөрсөн нь хугацаа өнгөрсөн байсан ч гэсэн мэдээллийг цуглуулахыг зөвшөөрсөнд тооцох үндэслэл болохгүй гэхээр яг таны талд ярьж байгаа. Таны ярьж байгаа тэр зарчимтай нийцэж байгаа байхгүй юу. Тэгэхээр хугацаа өнгөрсөн байсан нь хамаа байхгүй. Заавал тухайн мэдээллийг цуглуулж байгаа талд зөвшөөрлөө тэр мэдээллээ эзэн нь хариугаар өгөх ёстой. Өгөхгүй хугацаа өнгөрлөө ч байсан түүнийг мэдээлэл цуглуулсан зөвшөөрсөнд тооцохгүй гэж байгаа юм.

Тэгэхээр яг таны зарчимтай нийцэж байгаа гэсэн үг. Та бол нөгөө талаас нь тайлбарлаад байна. Тэгэхээр мэдээлэл цуглуулахыг зөвшөөрсөнд тооцох үндэслэл болохгүй гэхээр хугацаа өнгөрсөн эсэхээс үл хамааран заавал мэдээллийн эзэн хариугаа өгснөөр л тэр нь зөвшөөрсөнд тооцогдоно оо л гэсэн санаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Одоо санал хураалт явуулъя. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Төслийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн “хуульд зааснаас бусад тохиолдолд” гэсний дараа “мэдээллийг боловсруулах, цуглуулах, ашиглахдаа” гэж, 8.2.3 дахь заалтын “боловсруулах,” гэсний өмнө “цуглуулах,” гэж тус тус нэмж, 8.2.6 дахь заалтын “мэдээллийн төрөл, агуулга” гэснийг “мэдээллийн жагсаалт” гэж, 8.2.7 дахь заалтын “цуцлах нөхцөл” гэснийг “цуцлах хэлбэр” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

72,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гишүүдээс бичгээр гаргасан санал алга байна.

Хуулийн төслийн 9 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй 1 санал байна.

Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.1.Энэ хуулийн 4.1.2-т заасан эрүүл мэнд, захидал харилцаа, генетик, биометрик, тоон гарын үсгийн хувийн түлхүүр, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, бэлгийн харьцааны талаарх хүний эмзэг мэдээлэл нь хувь хүний нууцад хамаарна.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор

Сандаг-Очир гишүүн асуултаа асууя. Манай Сандаг-Очир гишүүний төрсөн өдөр болж байгаа, өнөөдөр. Баяр хүргэе.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Энд хөрөнгөө авчихсан юм байна, тийм ээ. Хөрөнгөө хасч байгаа юм байна. Эмзэг мэдээлэлд энэ цахим мэдээлэл орохгүй юу. Харин. Хамгийн их пейж, фейс хүний. Энэ одоо хамгийн их ормоор санагдах юм. Тэгээд хүний нууц руу кодыг нь мэдээд орчихдог. Тэгээд хамгийн одоо захидал харилцаатай л адилхан шүү дээ. Хүний дотоод хувийн нуцын мэдээлэл. Орчин үед бол энэ цахимжсан энэ нөхцөлд бол хамгийн их эмзэг мэдээлэл, хамгийн их мэдээлэлтэй зүйл бол энэ цахим орны мэдээлэл байгаа шүү дээ. Тэгэхээр энд энэ эмзэг мэдээлэлд цахим мэдээллийг оруулахгүй юу. Үүнийг тодруулж өгөөч.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн ахлагч. Хэн хариулах вэ. Баасандорж дарга хариул. Учрал гишүүн хариулъя.

Н.Учрал: Яг цахим мэдээлэл гэдэг тусдаа томьёолол байхгүй л дээ. Тэгэхээр энэ дотор хүний хувийн мэдээлэл, хүний эмзэг мэдээлэл гэж мэдээллээ ангилаад эмзэг мэдээлэлд хамааруулсан мэдүүллүүдийг бол хувь хүний нуцад хамааруулж байгаа юм. Тэгээд тэндээс нь хөрөнгийг нь аваад хүний хувийн мэдээлэл рүү оруулсан гэсэн үг. Тэгэхээр хүний жишээ нь, хувийн мэдээлэл бол цахим хэлбэрээр ч өөр ямар нэгэн хэлбэрээр байж болно. Тэгэхээр цахим мэдээлэл гэдэг ойлголт биш түүнийг ямар нэгэн цахимаар байна уу цаасаар байна уу мэдээллийг л дотор нь ангилж байгаа. Тэр цахимтай холбоотойгоор таныг сая хэлж байгаагийн дагуу бид нар хүнд давтагдашгүй 1 удаа олгогдох тэр тоон гарын үсгийн хувийн түлхүүрийг бол энэ эмзэг мэдээлэлдээ бас оруулж өгч байна.

Мөн энэ хувь хүний нуцад хамааруулсан мэдээллүүдийг нуцынхаа хуулиар зохицуулж явна гэсэн ийм ойлголт байгаа. Ажлын хэсгээс нэмж хариулна.

С.Бямбацогт: Цахим мэдээллийг оруулж өгөөч ээ гэзд байна шүү дээ тийм үү. Цахим мэдээлэл чинь захидал харилцаанд орж байгаа юм уу. Орохгүй байгаа юм уу. Тодорхой хариулчихъя. Баасандорж дарга хариулъя. 3 дугаар микрофон.

Б.Баасандорж: Гишүүний асуултад хариулъя. Сая ажлын хэсгийн ахлагч Учрал гишүүн ерөнхийд нь хариулчихлаа. Би нэмээд хариулъя. 9.1 дээр захидал харилцааг оруулж өгсөн байгаа. Захидал харилцаанд саяын гишүүний хэлсэн цахим мэдээлэл орж байгаа. Өөрөөр хэлбэл 4.1.2 дээр бас хүний эмзэг мэдээлэлд захидал харилцааг оруулж өгсөн байгаа. Энэ захидал харилцаа маань хүний эмзэг мэдээлэлд хамаарна. Мөн хувь хүний нуцад хамаарна.

Мөн захидал харилцаа гэж захидал, илгээмж, цахим шуудан, шуудан холбоо, мэдээллийн технологи ашиглаж солилцож байгаа мэдээллийг хэлнэ гэж байгаа. Тэгэхээр өөрөөр хэлбэл энэ дээр нөгөө цахим шуудан, пин код, тухайн 4.1.1 дээр байгаа хүний хувийн мэдээлэлтэй холбоотой ийм зүйлүүд хамааraад явчхаж байгаа юм. Захидал харилцаандаа.

С.Бямбацогт: Асуулт асууж, хариулт авч дууслаа. Саналын томьёоллыг сая уншиж танилцуулсан. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

76,5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гишүүдээс бичгээр гаргасан санал алга байна.

Хуулийн төслийн 10 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсгээс 1 санал байна.

Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалтын “эрүү, иргэн, захиргааны болон бусад” гэснийг, 10.2 дахь хэсгийн “Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэн тогтоосон” гэснийг тус тус хасч, 10.2 дахь хэсгийн “ажилтны” гэсний дараа “зөвшөөрлөөр” гэж нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 10.1.5 дахь заалт нэмэх:

“10.1.5.Монгол Улсын Их Хурлын гишүүн хуралдааны ирцэд бүртгүүлэх, санал хураалт явуулах зорилгоор хүний биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/-ийг.” гэж нэмэх юм байна тийм ээ. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

82,4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Гишүүдээс энэ зүйл дээр бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 11 дүгээр зүйлтэй холбогдуулан ас уулт асуух гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсгээс 1 санал байна.

Төслийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсгийн “Энэ хуулийн 11.1, 11.3-т заасан зорилгоор” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

82,4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 12 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Энх-Амгалан гишүүн асуултаа асууя. Б.Энх-Амгалан гишүүн.

Б.Энх-Амгалан: Энэ төслийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь заалт. Бэлгийн чиг хандлага, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа илэрхийлэл энэ тэр гэж өөрчлөх гээд. Энэ сүүлийн үед ижил хүйстнүүдийн жагсаал болоод л тэндээ жоохон хүүхдүүдийг оролцуулаад л бэлгийн байтугай нас биед ч хүрээгүй хүүхдүүдийг авч жагсаагаад ингээд явах юм. Тэгээд бэлгийн цөөнх гэж нэрлээд өөрсдийгөө нэрлээд байгаа тэр ижил хүйстнүүд чинь тусдаа гадна талаас санхүүждэг. Байр савтай. Төрийн бус байгууллагатай, хангамж өндөртэй ийм болоод байна гэх юм. Энэ цаашдаа Монгол Улсын хүн ам зүйн бодлогод нөлөөлөх

ийм нөхцөл байдал үүсэх юм биш биз дээ. Үүнийг хувь хүний эрх гэж хамгаалаад үүнийг хуулиар дэмжээд байх шаардлага хэрэгцээ юу байгаа юм. Үүнийг яаж зохицуулах гэж байгаа юм. Энэ талаар хариулт өгөөдөхөөч.

С.Бямбацогт: Сайнзориг 2 дугаар микрофон.

П.Сайнзориг: Энх-Амгалан гишүүний асуултад хариулъя. Мэдээж яг энэ асуудал тодорхой зохицуулалтууд одоо ч гэсэн оршиж байгаа. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, Монгол Улсын Эрүүгийн хууль байна. Хүүхдийг садар самуунд уруу татах, эргээд энэ зүй бус янз бүрийн харилцаанд оруулах асуудал байх юм бол эргээд Эрүүгийн хуулиар зохицуулж, Эрүүгийн хуулийн санкц үйлчилж байгаа. Энэ хуулиар мэдээж хүүхдийн бас холбоотой эмзэг мэдээллүүд хамгаалагдах, түүний хууль ёсны төлөөлөгч бас тодорхой шийдвэр гаргахад оролцох энэ нөхцөл зохицуулалтууд орсон байгаа. Тэгэхээр ер нь зүгээр хүүхэдтэй холбоотой аливаа мэдээлэл болгон л эмзэг байдаг. Энэ агуулгаараа зохицуулалтууд. Тийм. Эмзэг мэдээлэлд орж байгаа. Энэ нь өөрөө эргээд бас хамгаалахаас өөр аргагүй эргээд энэ мэдээлэл дэлгэгдэх тусам магадгүй хувь хүн хүсээгүй байж байхад дэлгэгдэх нь тухайн хүнийг нийгэмд ялгаварлан гадуурхалтад өртөх ч гэдэг юм уу зүй бус халдлагад өртөх ийм зүйлүүд байгаа.

С.Бямбацогт: Тэгэхээр энэ дээр бэлгийн чиг хандлага гэдгийг чиг хандлагаас тодруулсан юм байна шүү дээ тийм ээ, нарийвчлаад. Бэлгийн болон хүйсийн чиг баримжаа. Чиг баримжаа тийм ээ. Хандлагаас гадна чиг баримжаа гэдэг чинь бас арай жоохон өөр агуулга байх л даа. Нууц байх ёстой байх. Түүний илэрхийлэл гэж оруулсан юм байна тийм ээ.

Санал хураалт явуулъя. Саналын томьёолол танилцуулсан.

Төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “мэдээллийн эзний зөвшөөрлөөр” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

82,4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Төслийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь заалтын “бэлгийн чиг хандлага,” гэснийг “бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл,” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт явуулъя.

76,5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гишүүдээс бичгээр гаргасан санал алга байна.

Хуулийн төслийн 13 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гаргаагүй байна. Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 14 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гаргаагүй байна. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 15 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсгээс 1 саналтай байна. Уншиж танилцуулъя.

Төслийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “цуглуулж, боловсруулж, ашиглаж байгаа” гэснийг хасч, 15.1.3 дахь заалтын “цуглуулснаас” гэснийг “цуглуулж, боловсруулснаас” гэж, “эсхүл гэрээнд заасан,” гэснийг “гэрээнд заасан, эсхүл харилцан тохиролцсон” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

82,4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 16 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсгээс санал гаргаагүй байна. Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 17 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гаргаагүй байна. Бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 18 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Раднаасэд гишүүн. Кнопоо дараарай.

Ш.Раднаасэд: Энэ мэдээлэл хариуцагч гээд одоо энэ байгууллага болоод эхэлж байна л даа. Эзнээс зөвшөөрөл аваагүй гэдэг үндэслэлээр мэдээлэл өгөхгүй байх нөхцөлийг энэ 18.2.1 өөрсдөө нэг журам баталж мөрдүүлнэ. Дахиад ар талд нь очоод 20.1.1 гээд аюулгүй байдлын журмыг бас мөрдөнө гээд. Одоо энэ дотор чинь их юм болно оо. Ялангуяа шүүх дээр очиход өмгөөлөгч нар тодорхой лавлагаа авахыг хүсдэг. Хөрөнгийн бирж байна уу энэ хуулийн этгээдийн бүртгэлийн газар байна уу. Ялангуяа олон харилцагчтай газрууд дээр. Гэтэл энэ дээрээс зөвшөөрөл ирээгүй гэдэг үндэслэлээр энэ лавлагаанууд өгөгдөхгүй байх ийм нөхцөл үүсэх үү. Энэ ХК дээр бас нэг том юм байна шүү. Жижиг хувьцаа эзэмшигчид нь тодорхой мэдээллийг үнэн гүйцэд авч чаддаггүй. Түүнийхээ араас хөөцөлддөг. Хөөцөлдөхөөрөө заавал шүүхээр алданги гаргуулахаар хүртэл эцсийн мөчдөө тийм юм руу хүртэл явдаг. Өөрөө хүсэлт гаргаад тухайн байгууллагаас ямар нэгэн байдлаар мэдээлэл авах гээд тэр нь хаалттай. Манай ийм журмын дагуу өгөх боломжгүй ч гэдэг юм уу. Ийм руу аваачаад хийчих вий. Энэ зохицуулалт чинь энэ дотроо орж байгаа юу. Энэ хуулийн чинь амин сүнс бол тэр өөрт хамаарах мэдээллээс бусад мэдээллийг чинь хамгаалж өгөх гээд байгаа шүү дээ, нэг талдаа.

Нөгөө талдаа энэ өөрт байгаа эрхийг нь эдлүүлэхийн тулд байдаг. Гэтэл энэ дээр чинь хууль дотроо 2, 3 газар ийм жижиг мэдээлэл хариуцаж байгаа этгээдийн өөрөө хамаг юмаа хамгаалах ийм журмуудыг хийгээд өгчхөөр амин сүнсийг чинь энэ журмууд чинь баллаад хаячихна даа.

С.Бямбацогт: Баасандорж дарга хариулъя. 3 дугаар микрофон.

Б.Баасандорж: Раднаасэд гишүүний асуултад хариулъя. 18 дугаар зүйлтэй холбоотой мэдээлэл хариуцагчийн талаар асууж байна. Ер нь мэдээлэл хариуцагч гэж 5 субъектийг хэлж байгаа. Нийтийн мэдэллийн тухай хуулиар, одоо бидний дараагийн хэлэлцэх. Энэ дээр төрийн байгууллагууд орж байгаа. Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой эрх зүйн хуулийн этгээдүүд орж байгаа. Мөн олон нийтийн радио телевиз, улс төрийн нам гэх зэрэг 5 этгээдийг субъектийг мэдээлэл хариуцагч гэж үндэслэж явж байгаа.

Бид нар яг хүний хувийн мэдээллийн тухай хуулийн 8.6 дээр ер нь мэдээллийн эзнээс ямар мэдээллийг нь авах дээр зөвшөөрөл авах юм. Түрүүн Сандаг-Очир гишүүний хөндөж байсан 8.6 дээр яг мэдээллийн эзэн зөвшөөрөөгүй бол хориглож өгч байгаа. Энэ бол илүү нөгөө иргэн талдаа ашигтай заалт 8.6 бол иргэн тал руугаа яаж байгаа.

Саяын Раднаасэд гишүүний хэлсэн тэр өмгөөлөгч, хуульчтай холбоотой зүйлүүд бол мэдээж Эрүүгийн процессын хууль, иргэний процессын хууль, захиргааны процессын хуулиудаар тухайлсан хуулиараа зохицуулагдаад явна. Тэр хуулиар явна. Гэхдээ энэ хуулиар бас ямар мэдээллийг нь мэдээллийн эзний зөвшөөрөлтэйгөөр авах юм, ямар мэдээллүүдийг нь авч болохгүй юм бэ гэдэг зүйлийг нь 8 дугаар зүйл, 18 дугаар зүйл. Тэгээд мэдээлэл хариуцагч яг ямар үүрэг хүлээх юм. Мэдээллийн эзний өмнө гэдгийг зохицуулж өгч байгаа юм. Тэр тухайлсан хуулиудаар зохицуулагдах асуудлууд байгаа. Процессын хуулиудаар хэрэг маргаан шийдвэрлэх.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн гишүүн Сүхбаатар гишүүн нэмж хариулъя.

Ж.Сүхбаатар: Раднаасэд гишүүний асуудал бол арай чухал асуудал асуудал байсан л даа. 18.2.1-ийн тэр журам баталж мөрдүүлнэ гээд байна шүү дээ. Тэгээд журмаараа нөгөө яриад байгаа юмнуудыг чинь үгүйсгэчих вий л гээд байгаа юм. Тэгэхээр энэ хууль чинь зарим хүмүүс бас шүүмжлээд байгаа шүү дээ. Хэтэрхий зарим юмыг детальчихлаа гээд байгаа. Тэгэхээр энэ хуульд бол хамгийн чухал гол тэр процесс процедур яг авч өгөх юм, яах юм гэдэг энэ юмнуудыг ингээд хийчхэж байгаа учраас хуульд гол заалтууд нь ер нь суучихсан гэж одоо үзэл баримтлалыг нь харах юм бол тэгж ойлгохоор. Тэр журам нь тэр хуульдаа нийцэж л гарна гэж байгаа. Мэдээж энэ журмыг хол хүн гаргахгүй. Сая тэр Баасандорж даргын хэлдгээр тэр захиргааны байгууллагууд ийм журмыг бол захиргааны байгууллага болон бусад тэр аж ахуйн нэгж байна уу ингээд журмаа баталж мөрдүүлнэ. Гэхдээ энд нийцүүлнэ гэж байгаа байхгүй юу. Одоо бол энэ, тэгээд таны хэлдэг эрсдэл бий л дээ. Тэгээд журмаа хуульд нийцүүлэхгүй гаргачих юм бол ялангуяа захиргааны актыг бол манай Хууль зүйн яам юм хумаа хянах ёстой байхгүй юу даа. Норматив, хэм хэмжээ тогтоосон актуудыг бүртгэдэг шүү дээ. Тэгэхдээ үүнийг чинь хянаад явах ёстой. Ер нь тийм асуудлууд бол одоо ч гараад л байгаа. Сүүлд гарлаа гэхэд тэр зөрчлүүдийг бид нар энэ хуулиар бариад арилгаж байх ёстой байхгүй юу. Тэр хуулиас давсан журам гаргаад байвал. Захиргааны шүүхэд хандаж хүчингүй болгож болно. Бүртгэл дээр тавих хяналтаар явж болно. Бусад этгээд шаардаад түүнийг залруулж болно. Тэр хуульд нийцүүлнэ гэдэг үг 18.2.1-д яваад байгаа байхгүй юу. Илүү детальчилж бичсэнгүй гэвэл нэг өөр байх л даа.

С.Бямбацогт: Раднаасэд гишүүн тодруулъя.

Ш.Раднаасэд: Болгоомжлол юм л даа. Жишээлбэл, ийм бодитой юм байгаа байхгүй юу. Өөрийнхөө нэр дээр газар авчихсан байдаг. Гэтэл өөрт нь мэдэгдэлгүйгээр газрыг нь дахиад хуваарилчихсан. Тэгээд энэ газрыг хуваарилчихсан гээд ингээд өөр хүмүүс яваад байна. Би мэдээлэл авъя гэхээр Газрын алба мэдээллийг нь өгдөггүй юм. Энэ мэдээллээ авахын тулд тэр хүн чинь шүүхийн журмаар гаргуулах гээд шүүхэд хандаад хүртэл явж байгаа байхгүй юу. Энэ бол хуулийн этгээдийн бүртгэл дээр ч гэсэн асар их ийм юмнууд. Энэ ХК-ууд дээр их юм гардаг. Хөрөнгийн бирж дээр. Энэ чинь өөрөө яг 5 субъектэд хамаарна гээд байгаа. Төр нь өөрөө энэ дотроо орчхож байгаа бол аль болохоор өөрийгөө

хамгаалсан юмыг л бүрэн төгс утгаар нь хуулийн дагуу хийнэ л дээ. Хязгааргүйгээр үүнийг нь эрхийг нь тавиад өгчхөж байгаа байхгүй юу. Тухайн байгууллагууд дээр. Миний болгоомжилж байгаа юм энэ л байгаа юм. Заавал хариулаад байх албагүй л дээ.

С.Бямбацогт: Хариулчихъя. Сая эргэлзээтэй заалтууд дээр тодруулж явах ёстой, бид нар тийм ээ. Хэн хариулах юм. Сайнзориг 2 дугаар микрофон. Сайнзориг дарга хариулъя.

П.Сайнзориг: Раднаасэд гишүүнд товчхон хариулъя. Ер нь мэдээллийн эзэн буюу хүн тухайн тэр хүнтэй холбоотой мэдээлэл хувийн хэвшлийн байгууллага дээр ч байна уу төр дээр ч байна уу үүнийг чөлөөтэй авч ашиглах эрхийг нь энэ хуулиар баталгаажуулж өгч байгаа юм. Тэгэхээр таны ярьж байгаа сүүлийн кейс дээр бол энэ газартай холбоотой лавлагаа мэдээллээ авъя гэхэд ямар нэгэн хориг саадгүйгээр авч ашиглах энэ бүх бололцоог төрийн байгууллага энэ мэдээллийг агуулж байгаа этгээд бүр авч өгөх ёстой.

Яг энэ 18.2.1 дээр хуульд нийцүүлэн гээд сая Сүхбаатар гишүүн хэлж байна. Үүндээ л гол нюанс нь байгаа. Энэ бол дотооддоо байгууллага мөрдөх. Байгууллага болон хүний хувийн мэдээллийг цуглуулахдаа замбараагүй байж болохгүй ээ гэдэг л асуудал байгаа. Хэн нь ямар процедураар цуглуулах юм, тэр мэдээллийг мар нөхцөлд хадгалж байх юм. Хэн дуртай нь үзэж байх юм уу эсвэл байгууллагын удирдлагын зөвшөөрлөөр үзэж байх юм уу гэдэг ч юм уу ийм байдлаар байгаа. Тэгэхээр энэ ажилчдынхаар нь эхлээд үйлчлүүлэгчийн бүх мэдээлэл цугларч байгаа байхгүй юу. Тэгэхээр үүнийг бас юу гэдэг юм хямгатай байлгах үүднээс дотооддоо ийм журмыг мөрдүүлээрэй гэж байгаа юм.

2 дугаарт яах вэ, Хүний эрхийн Үндэсний … /минут дуусав/

С.Бямбацогт: гүйцээгээд хариулчихъя.

П.Сайнзориг: Хүний эрхийн Үндэсний Комисс энэ хуулийн хяналт дээр буюу тодорхой энэ хүний хувийн мэдээллийг хамгаалах асуудлаар гомдол мэдээллийг авдаг комиссар ажиллана. Энэ комиссар бас тодорхой хэмжээний байгууллагууд цуглуулсан мэдээллээ яг зохих зорилгын дагуу ашиглаж байна уу эсвэл буцаагаад одоо юу гэдэг юм зарим байгууллагууд цуглуулсан үйлчлүүлэгчийн мэдээллийг маркетингийн компаниудад өгчихдөг. Зөвшөөрөөгүй байхад нь. Тэгэнгүүт утсан дээр хүсээгүй мессежүүд ирдэг ч юм уу ийм байдлаар байдаг. Энэ буруу жишгүүд л үндсэндээ цаашаа цэгцэрч тодорхой хэмжээний асуудлууд цэгцрээд явах ёстой. Тэгэхдээ ер нь Раднаасэд гишүүний хэлж байгаагаар бүх мэдээллийг хаалттай орчинд байлгая биш зохистой хэмжээнд эргэлтэд зөв оруулъя. Хэрэглэе гэдэг л асуудал энэ хуулийн гол зохицуулалт концепц нь яваа.

С.Бямбацогт: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. 18 дээр гишүүдээс санал байхгүй. Ажлын хэсгээс санал байхгүй байна.

Хуулийн төслийн 169 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсгээс 1 санал байна.

Төслийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийн “мэдээллийн ангилал” гэснийг “мэдээллийн жагсаалт,” гэж, 19.4.7 дахь заалтын “мэдээлэл хариуцагчийн өгсөн үүрэг, зааврыг” гэснийг “мэдээлэл хариуцагчийн өгсөн үүрэг, чиглэл, даалгаврыг”

гэж тус тус өөрчилж, 19.3 дахь хэсгийн “шилжүүлсэн тохиолдолд мэдээлэл боловсруулагчид хүлээлгэх” гэснийг, 19.4.2 дахь заалтын “мэдээллийн эзний” гэснийг, 19.4.4 дэх заалтын “буцааж” гэснийг болон 19.6 дахь хэсгийг тус тус хасч, 19.4.6 дахь заалтын “энэ хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу” гэсний дараа “мэдээллийн” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

64,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гишүүдээс бичгээр гаргасан санал алга байна.

Хуулийн төслийн 20 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Энх-Амгалан гишүүн.

Б.Энх-Амгалан: Энэ мэдээллийн аюулгүй байдалтай холбоотой заалт байна л даа. Энэ дээр мэдээлэл ашиглахыг хязгаарлах, мэдээллийг устгах, мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй болох талаар журам зааварчилгаа гаргаж мөрдөнө энэ тэр гээд. Энэ Хув хүний нууцын тухай хуулийг хэрэглэхэд зохицуулалтын агуулга нь хэт ерөнхий тунхаглалын шинжтэй байгаа учраас үүнийг тодорхой болгоно гээд байдаг. Гэтэл хувь хүний чинь захидал харилцаа, чат, мессеж, мессенжер, фейсбүүкийн мэдээлэл, хувийн гэрэл зургийн мэдээлэл гээд ингээд янз янзын юмнууд гараад ирдэг. Энэ аюулгүй байдлаа ер нь яаж хангах юм. Тэгээд 1 талдаа болохоор зэрэг хэвлэл мэдээллийн байгууллага тэр мэдээлэл олж авч байгаа эх үүсвэрээ заавал эзнээс нь асуух шаардлагагүй, тэгэхгүй, ингэхгүй гэчхээд нөгөө талаараа ингээд мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах, хэрэглэх гээд аюулгүй байдлыг нь ямархуу байдлаар хангана гэж энд тусгаж байгаа юм.

Хамгийн гол нь одоо бол энэ цахим аюулгүй байдал ч бай орчинд бол ер нь цахим халдлага гэдэг юм чинь жигтэйхэн байна шүү дээ. Тэгээд мэдээллийн аюулгүй байдлаа хангахын тулд энэ цахим халдлагаа яаж зохицуулах гэж байгаа юм. Цахим гүтгэлгээ яаж зохицуулах гэж байгаа юм. Хүний нэр төрд, удам сударт нь, эрхэлж байгаа албан тушаалтай нь холбоотой нь, эд хөрөнгөтэй нь холбоотой нь, үзэл бодолтой нь холбоотой нь ингээд дайраад доромжлоод л давшлаад л нийгмийн шаар шавхруу болтол нь ингээд гүтгээд байгаа энэ мэдээллийн аюулгүй байдлыг нь яаж хангах юм. Энэ тал дээр тодорхой мэдээллүүд өгөөдөхөөч.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн ахлагч Учрал гишүүн хариулъя.

Н.Учрал: Энх-Амгалан гишүүний асуултад хариулъя. Эхний хэлж байгаа санаа дээр мэдээлэл хариуцагч, мэдээлэл цуглуулах боловсруулах үүргийг гэрээний үндсэн дээр мэдээлэл боловсруулагчид шилжүүлж болно гэдгийг 19.1 дэх заалт байгаа. Тэр нь мэдээлэл хариуцагч буюу мэдээллийг цуглуулж, боловсруулж байгаа тал түүнийг өөр субъектээр боловсруулуулж болно. Гэхдээ тэр мэдээлэл боловсруулж байгаа тал түүний аюулгүй байдлыг хангах ёстой гэдэг энэ агуулгыг оруулж өгсөн. Энэ нь 20 дугаар зүйл дээр мэдээлэл хариуцагч 19.1-д заасан мэдээлэл боловсруулагч нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээнүүдийг авах гээд тодорхой 5 арга хэмжээг авах буюу мэдээллийн аюулгүй байдлыг хангахад үнэлгээ хийх, журам зааварчилгааг мөрдөх, бүхий л арга хэмжээг авсан байх. Төрийн байгууллагад мэдээлэл хүргүүлэх төлөвлөгөөг хуульд нийлүүлэн батлах гээд ийм 5 арга хэмжээг бол энд тусгаж өгсөн. Энэ хуулиар бол.

Үүнээс гадна яг Энх-Амгалан гишүүний хэлж байгаа дээр бид 4 хуулийн ажлын хэсгийг байгуулсан, хамтарсан. Эдгээр хуулиуд хоорондоо уялдаатай. Ирэх 7 хоногт бас Кибер аюулгүй байдлын хуулийн анхны хэлэлцүүлгийг хийхээр төлөвлөж байна. Кибер аюулгүй байдлын хууль дээр бол кибер аюулгүй байдлын тогтолцоог маш тодорхой болгож өгч байгаа. Тэгэхээр төрийн байгууллагууд буюу хууль хяналтын байгууллагууд ямар үүрэг хүлээх юм. Салбар дундын мэдээллийн аюулгүй байдлыг хэрхэн хангах юм. Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй төрийн болон хувийн байгууллагуудын мэдээллийг хэрхэн хамгаалах юм бэ гээд үндэсний төв ажиллах, төрийн төв ажиллах, тэр төвүүдийг энэ Кибер аюулгүй байдлын хуулиар тодорхой болгож байгаа. Ингээд Кибер аюулгүй байдлын зөвлөл байгуулж салбар дундын мэдээллийн аюулгүй байдлыг хангах тогтолцоог боловсронгуй болгохоор энэ хуульд оруулж ирнэ. Тэгэхээр Кибер аюулгүй байдлын хууль дээр энэ асуудлууд бас тодорхой тусаж байгаа.

Энэ Хувь хүний мэдээлэл хамгаалахтай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулж байгаа. Гэхдээ 20 дугаар зүйл дээрээ 5 техникийн арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг нь хуулиар нь нээж өгсөн. Тэгэхээр ер нь бол цуглуулж байгаа, боловсруулж байгаа, ашиглаж байгаа тал бол мэдээлэл хариуцагч бол тэр мэдээллийн аюулгүй байдлыг хангах үүргийг давхар энэ хуулиар хүлээж байгаа гэдгийг хэлье.

С.Бямбацогт: Төслийн 20 дугаар зүйлийн гарчгийн “Аюулгүй байдлыг” гэсний өмнө “Мэдээллийн” гэж, 20.1.1 дэх заалтын “мэдээллийн аюулгүй байдлыг хангах” гэсний өмнө “энэ хуулийн 20.2-т заасан шаардлагад нийцүүлэн” гэж тус тус нэмж, 20.1 дэх хэсгийн “чиглэлээр зохион байгуулалтын болон техникийн” гэснийг “талаар” гэж, 20.1.4 дэх заалтын “мэдээллийг тодорхойлох боломжгүй болгох талаар тодорхой” гэснийг “мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй болгох талаар” гэж тус тус өөрчлөх. Ажлын хэсгээс гаргасан санал байна. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

64,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Дараагийн санал хураалт. 20 дугаар зүйл дээр.

Төслийн “харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэснийг “цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж тохиолдол бүрд агуулгад нь тохируулан өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Яам болж байгаатай холбоотойгоор орж байгаа юм байна. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

70 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 21 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу. Энх-Амгалан гишүүн.

Б.Энх-Амгалан: Энэ хувь хүний мэдээлэлтэй холбоотой асуудал л даа. Хүний эмзэг мэдээллийг ашигласан, хүний мэдээллийг боловсруулах үндэслэл зорилгоор мэдээллийг аваад мэдээллийг гуравдагч этгээдэд дамжуулсан энэ тэр гээд ийм заалтууд байгаа юм. Энэ сургууль, курс ийм байгууллагууд ингээд өрхийн орлогын хэмжээ хэд үү, хаана ажилладаг вэ, яадаг уу, ийдэг үү, хаана амьдардаг

вэ, ямар эд хөрөнгөтэй вэ гээд л и нгээд л баахан судалгаа аваад байх юм. Тэгээд дараа нь байж байтал нэг тийм тоос сорогчны компаниас яриад байгаа юм шиг байхгүй юу. Үүнийг авах уу тэрийг авах уу гээд л. Хаанаас утас авсан нь бүү мэд. Ийм нөхцөл байдалд мэдээллийг яаж хамгаалах юм бэ. Хүссэн газар нь ингээд, хүссэн багш нь анкет бөглүүлээд мэдээлэл аваад байж болох юм уу. 1 дүгээрт.

2 дугаарт, би бол энэ хувь хүний мэдээлэлтэй холбоотой, цахим мэдээлэлтэй холбоотой, цахим аюулгүй байдалтай холбоотой, гүтгэлэгтэй холбоотой, доромжлолтой холбоотой ийм юмнуудыг бол Эрүүгийн хууль дээр нэмэлт нэг хатуухан заалт оруулчихмаар санагдаад байгаа юм. Хүнийг бол ерөөсөө, тэгээд эргээд тэр нь засрахгүй байхгүй юу. Гүтгээд доромжлоод нэр хүнд нь нийгэмд унаад ингээд дуусчихсаны хойно тэр бол хүчирхийлэгч болоод хувирчихдаг. Мянга дараа нь тийм биш байна гээд нэмэр байхгүй. Тэр тийм юм гэнэ лээ гээд. Эхний гарсан мэдээлэл бум болж явчхаад л тэгээд дараа нь түүнийг мянга цайруулаад нөгөө буруугүй гэдэг залруулгаа булан дээр нь нөгөө жижигхэн буруугүй байна лээ гээд биччихсэн. Түүнийг хэн ч олж хардаггүй гээг шиг л ийм явдаг учраас энэ нөхцөл байдлыг энэ хуулийнхаа хувь хүний аюулгүй байдлыг хамгаалах гэж байгаа мэдээллийг хамгаалах гэж байгаа хууль дотроо давхар Эрүүгийн хуульдаа оруулж өгөөч. Тэгэхгүй бол та нар фейсбүүктэй харьцаж чадахгүй шүү дээ. Хуурамч хаягийг та нар хааж чадахгүй байхгүй юу. Нэрээ нуусан, нүүрээ нуусан, хаягаа нуучихсан тийм хаягийг та нар хааж чадахгүй учраас түүн дээр чинь орж ирсэн юмнууд чинь шууд яваад ингээд хүн гүтгээд доромжлоод байх чинь бас тийм таатай биш байна шүү дээ. Ийм нөхцөл байдлуудыг нэг хараач.

С.Бямбацогт: Нэлээн бас анхаарах ёстой асуулт асууж байна шүү. Дээрээс нь нэмээд хариулахдаа даруй мэдэгдэл өгнө гээг маань даруй гэдэг чинь ямар хугацаа юм. Мэдээлэл гаргасныхаа дараа юм уу эсвэл мэдээлэл гаргахынхаа өмнө юм уу, тийм ээ. Дараа ч байсан өмнө ч байсан ямар хугацаанд байх юм. Нэмээд хариулчхаарай.

Учрал гишүүн хариулъя. Учрал гишүүний микрофон өгье.

Н.Учрал: Энх-Амгалан гишүүн маш чухал асуудлыг хөндөж байгаа юм аа. Энэ өмнөх хувь хүний нуцын хуулиар бол иргэн өөрөө л тэр мэдээллийнхээ аюулгүй байдлыг хангадаг, хариуцдаг байсан. Одоо энэ хуулиар бол яг таны хэлж байгаагаар цуглуулж байгаа, боловсруулж байгаа тал буюу мэдээлэл хариуцагч тэр мэдээллийн аюулгүй байдлыг нь хангах ийм үүргийг хүлээж байгаа юм. Тэгэхээр жишээ нь, сая та бүхэн мэдэж байгаа. Энэ и-монголиа-тай холбогдуулаад энэ үндсэн систем дээр төр иргэдийн мэдээллийг цуглуулж байгаа бол тэр мэдээлэл хариуцаж байгаа тал үүрэг хүлээх ёстой. Гэтэл ямар чиглэлээр таны иргэний үнэмлэхийг ашигласан бэ гэдгийг бид мэдэж чадахгүй байна шүү дээ. Жишээ нь, газрын гэрчилгээ авахад тэнд иргэний үнэмлэхийг чинь ашиглалаа. Та жолооны үнэмлэхээ авах гэж байгаа учраас иргэний үнэмлэхийг чинь ашиглалаа гэж байгаа бол иргэн хүн заавал тэр мэдээллийг маань төр ингээд ашигласан юм байна аа гэдэг талаараа мэдээллийг авч байх ёстой. Тэгэхээр энэ хууль дээр мэдээллийн эзэнд мэдэгдэл очих буюу нотпикейшн явуулна гээд байгаа нь бас хуулийн гол амин сүнс юм байна аа гэж ажлын хэсэг ойлгож байгаа. Жишээ нь, миний мэдээллийг төр ийм учраас ашиглажээ. Өөр чиглэлээр ашиглаагүй байна гээд. Тэгэхээр иргэн бол миний төрд байгаа мэдээллийг төр ийм хэлбэрээр ашиглаж боловсруулж байна аа гэдэг талаар мэдээллийг авахгүй болохоор төрийн ямар нэгэн мэдээллийг хувийн тэр байгууллагууд маркетингийн зорилгоор

судалгааны зорилгоор ашиглаад байх эрсдэл бол угаасаа байгаа. Гааль, татварын санхүүгийн мэдээллийн алба гэзд байгууллага хүний амьжиргааны түвшинг тодорхойлж байгаа шүү дээ. Жишээ нь, нөгөө хөнгөлөлтийн эмийн тарифаар аптекуудаар эм авч байгаагаас нь болоод энэ дүүрэг, хороо ийм чиглэлийн өвчлөл илүүтэй байна аа гэдгийг нь хувийн бизнес эрхэлж байгаа байгууллагуудад өгснөөрөө тухайн тэр эм ханган нийлүүлж байгаа байгууллага тэр чиглэлийн эмийг оруулж ирэх нь ашигтай юм байна аа гэзд мэдээлэл дээр нь бизнес хийж байгаа тохиолдлууд гарч байгаа шүү дээ. Би өмнө нь ч хэлж байсан. Өмнөх тэр сонгуулийн үеэр хүртэл танай хорооны иргэдийн өвчлөлийн мэдээлэл энэ тэр гэзд явж байсан нөхөд хүртэл гарч байсан. Гэтэл үүнээс чинь болоод хэн хариуцах нь тодорхойгүй байсан. Тэгэхээр одоо бол энэ хууль гарснаар би юу харж байна вэ гэхээр ядаж төр миний мэдээллийг ийм чиглэлээр ашиглаж байгаа юм байна аа гэдгийг нотпикейшн маягаар тэр и-мейл маягаар надад ирэх юм байна. Би гадаад паспорт авахад миний иргэний үнэмлэхийг ашиглажээ. Ийм тохиолдолд миний энэ гэрчилгээг, гэрлэлтийн баталгааг ашиглажээ гэдэг ч юм уу энэ мэдээллүүд нь мэдээллийн эзэндээ мэдэгдэл өгөх маягаар очих юм байна.

Хоёрт бол энэ хувь хүний мэдээллийг хамгаалж байгаа гэдэг утгаараа Хүний эрхийн Үндэсний Комисс үүн дээр нэлээн тодорхой үүрэг хүлээж оролцоно. 24 дүгээр зүйл дээр тэр хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах, холбогдох байгууллагуудад хүргүүлэх журамд нь санал өгөх, шаардлага хүргүүлэх гэзд энэ тодорхой үүргүүд бол Хүний эрхийн Үндэсний Комисс дээр очиж байгаа. Тэгэхээр хувь хүний мэдээлэл хамгаалах тэр Хүний эрхийн Үндэсний Комисс шууд оролцох боломж нь хуулиар нээгдэж өгч байгаа учраас өмнөх шиг тийм зохион байгуулалтгүй цуглуулдаг одоо тэр тоос сорогч авах уу гэзд залгадаг. Хаанаас гар утсыг нь. Ер нь бол ийм зохицуулалт хийгдэж байна аа гэзд дэвшил болж байна аа гэж хэлж байна.

С.Бямбацогт: Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа. Хариулт хангалттай юу. Баасандорж дарга нэмээд хариулчихъя.

Б.Баасандорж: Энх-Амгалан гишүүний асуултад хариулъя. Саяын Энх-Амгалан гишүүний асуусан асуулт бас л яг өнөөдөр тулгамдаад байгаа эмзэг асуудлын нэг л дээ. Асуудал нь. Одоо жишээ нь, яг сургуулийн багш нар хүүхдүүдэд хичээл заах байтал тухайн хүүхдээс тэр өрхийн эцэг эхийнх нь ажлын байдлын тодорхойлолтыг асуудаг. Хаана ажилладгийг нь асуудаг. Өрхийн орлогыг нь асуудаг. Одоо та бүхний хүүхдүүд ч гэсэн ингээд ийм 2 хуудас цаас өгөөд явуулчихдаг. Бөглөөд ирээрэй гэдэг. Уул нь багш бол тэр хүүхдэд хичээл заах л үүрэгтэй. Ямар нэгэн мэдээлэл асуух, ямар нэгэн эцэг эхийнх нь талаар асууж болохгүй. Тэгэхээр энэ нь өөрөө, тэгэхээр манай хууль бол яг үүнийг л зохицуулах гэзд байгаа юм. Одоо Япон, Солонгос бол яг ингэж зохицуулдаг юм байна лээ. Одоо Баасандоржийн хүүхдэд хичээлээ л заа, Баасандоржтой холбоотой мэдээллийг тэр нийгмийн даатгалаас нь Нийтийн мэдээллийн хуулиас нь сургууль нь авчихдаг. Тэр ажил байдалтай холбоотой юмыг нь тэр нээлттэй мэдээллээс нь ингээд авчихдаг. Тэгэхээр яг энэ өөрөө асуудал байя гэвэл манай Боловсролын багц хуулийг шинэчлэх гол шалтгаан л манай боловсролын багш нарын боловсрол өөрөө бас имй. Зарим багш нар дээр. Байгаа юу гэвэл байгаа л даа. Эмзэг асуудал болчихсон.

Зарим тохиолдолд тэр мембер болж байгаа. Тухайн иргэн өөрөө зөвшөөрөөд тухайн худалдааны байгууллагад өөрөө мэдээллээ өгөх нь бол ондоо

асуудал байх. Ер нь бол энэ сургууль, эмнэлгийн байгууллагууд дээр янз бүрийн мэдээллүүдийг нэхдэг. Төрд байгаа мэдээллийг төрийн байгууллага нөгөө хүнээсээ нэхдэггүй байдлыг л энэ Нийтийн мэдээллийн болон хүний хувийн мэдээллээр л зохицуулах гээд байгаа юм. Яг 2 хуулиар. Саяын асуудлыг.

Тэр даруй гэдэг хугацааг бол Бямбацогт даргын асуусан. Тэр боломжит богино хугацааг даруй гэж байгаа шүү.

С.Бямбацогт: Учрал гишүүн хариулъя.

Н.Учрал: Ажлын хэсэг дээр бол энэ хувь хүний мэдээллийн хамгаалах нийтийн мэдээллийн хуулийг дагуулж ямар нэгэн тэр зөрчлийг чангатгах зохицуулалт оруулж ирээгүй. Бид нар ажлын хэсэг дээр тийм асуудал яриагүй. Түүнийг бол цахим орчинд тэр хүний эрхийг хамгаалах чиглэлээр Засгийн газар өөрсдөө хууль санаачлаад оруулж ирж байгаа гэдэг бид нарт мэдээлэл өгсөн шүү дээ. Тэгэхээр энэ хуулиудыг дагуулж тэр цахим орчин дахь хүний эрхийг хамгаалах янз бүрийн эрүүгийн хариуцлагыг нэмэгдүүлэх заалт оруулж ирэх ажлын хэсэг дээр ямар нэгэн асуудал яригдаагүй гэж хэлье.

С.Бямбацогт: Ер нь бол ажлын хэсэг маань нэлээн хариуцлагатай ажиллах ёстой. Ажилласан байх гэж найдаж байна. Ажиллах ёстой. Зарчмаа л барьж бид хуулиа хийх ёстой. Хэн нэгэнд таалагдах гэж юм уу тийм ээ, хэн нэгнээс дальдчиж айж эмээж хууль хийхгүй шүү. Үүнийг бас анхаарах ёстой.

Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1.2 дахь заалтын “мэдээллийг” гэсний өмнө “боловсруулсан” гэж нэмж, 21.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.2. Мэдээлэл хариуцагч энэ хуулийн 21.1-д зааснаас бусад тохиолдолд мэдээллийн эзний мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглахад мэдэгдэл хүргүүлж болно.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал 73,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

22 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Энх-Амгалан гишүүн.

Б.Энх-Амгалан: Энэ би санаа л хэлэх гэсэн юм. Зөрчил мэдээллийг эзний эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулахаар бол мэдээлэл хариуцагчдад мэдэгдэнэ. Мэдээлэл хариуцагчийн зөрчил, түүний улмаас учирсан болзошгүй сөрөг үр дагаврыг арилгана гээд юмнууд заачихсан. Түүн дээр Хүний эрхийн Үндэсний Комиссыг хяналтдаа авна энэ тэр гээд. Одоо ингээд бид нар нэг талаараа хүний эрх яриад байгаа юм. Нөгөө талаараа хүний эрхээс чинь болоод үндэсний өв соёлын зарим нэг юмнууд алдагдаад байгаа байхгүй юу. Одоо хүүхдээр морь унуулахгүй, тэгэхгүй, ингэхгүй баахан хорьчихсон чинь бүгд Өвөр Монгол руу гараад явчихлаа шүү дээ. Тэгээд уралдаан болгон дээр 200-300 юань авдаг. Хэрвээ айргийн 5-д орох юм 500 юань авдаг. Түрүүлэх юм бол 5000 юань авдаг ч гээд бүр ханш тогтчихсон. Тэгээд сард 5-6 сая төгрөгийн цалинтай болчихсон учраас амьдрахын эрхэнд явж байна аа. Ихэнх нь хөдөөний хүүхдүүд байна аа. Өвөр Монголын аймаг болгонд, хошуу болгонд, гацаа болгонд манайхан

байж байна аа. Уяачид нь оччихсон мориных нь хөлийг хатгаад л ингээд уяад байж байна аа гэж байна. Тэгээд Монгол үндэсний морины соёл бол БНХАУ-ын Өвөр Монголд байна аа гээд дэлхийд бүртгүүлээд байна аа. Энэ одоо юу вэ гэж. Энд баахан хүний эрх ярьж, хүүхдийн эрх хийчхээд хилийн гадна гарахаараа хамгаалдаггүй болчих юм бол энэ яах ёстой вэ.

Цаашлаад ирэхээр энэ Хүний эрхийн Үндэсний комисс энэ дээр хяналт тавина гээд байдаг. Яаж хяналт тавих юм. Яг үүнтэй холбоотойгоор та бүхэн маань бас нэг эрхийн зөрчил үүсээд байгаа юмыг нь яах юм. Хил гаргахаа байчих юм уу, эсвэл. 1 хуулийн заалтаар нөгөө юмаа хаадаг ийм нөхцөл байдал руу цаашаа явж боломгүй байгаа юм л даа. Энэ дээр та бүхэн бас энэ ажлын хэсэг дээрээ ярьж анхаараарай л гэж байгаа юм.

С.Бямбацогт: Анхаарах ёстой санал мөн боловч хэлэлцэж байгаа асуудалтай хамаагүй, холбоогүй байна.

Төслийн 22 дугаар зүйлийн 22.6 дахь хэсгийн “бүртгэлийг жил бүр” гэснийг “бүртгэлийг жил бүрийн 01 дүгээр сард” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

73,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 23 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гараагүй байна. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 24 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй 1 санал байна.

Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1.2 дахь заалтыг хасч, 24.1.4 дэх заалтын “хууль, эрх зүйн туслалцаа үзүүлэх” гэснийг “шаардлага, зөвлөмж өгөх” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

73,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 25 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал байхгүй байна. Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 26 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гаргаагүй байна. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 27 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Энх-Амгалан гишүүн асуултаа асууя. Дараа нь Алтанхуяг гишүүн.

Алтанхуяг гишүүн асуултаа асууя.

Н.Алтанхуяг: Энэ 2 хууль явж байгаа шүү дээ. 1 нь ингээд хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай гээд. Энэ бас нэг би дэвшил гарч байгаа л гэж бодож байгаа юм. Гэхдээ манай энэ Засгийн газрынхан бас ажлын хэсэг дээр бид нар нэлээн Их Хурал дээр нэлээн сайн ярих ёстой байх аа. Энэ 27 дугаар бүлэг бол манай нийгэмд бий болчхоод байгаа тийм ялзарсан юмыг л зохицуулах гээд байгаа шүү дээ. Шантааж, дуу дүрсний, дууны дүрсний, дуу дүрсний бичлэгийн янз бүрийн систем. Орцонд хүртэл тавьж байгаад шантаажилдаг ийм юм бий болсон. Тэгэхээр үүнийг л зохицуулах гэсэн ийм том дэвшилттэй зүйл болж байгаа юм. Би бол их зөв зүйл байна гэж бодож байгаа. Энэ манай иргэдэд ч гэсэн хууль батлагдсаны дараа үүнийг их сайн тайлбарлаж ойлгуулах ёстой юм. Одоо бид нарын энэ шинэ зохицуулалтаар юу болж байгаа вэ гэхээр орон сууцанд орох гарах нийтийн хэсэг, дундын эзэмшлийн талбай энэ тэрд бол зөвхөн ийм шаардлагатай бол дүрсний бичлэг, дуу байхгүй. Дуу дүрс хамт байхгүй гээд ийм нарийн зохицуулалтууд бас хийгдэж байгаа. Бас хориглож байгаа. Хаана хориглож байгаа вэ гэхээр ариун цэврийн өрөө, хувцас сольдог өрөө, нийтийн үйлчилгээний газрын, тусгай зориулалтын үйлчилгээний өрөө, караокены өрөө, зочид буудлын өрөө гээд ингээд тийм нарийвчилсан сайн хууль, ерөнхий утгаараа бол гайгүй хууль явж байгаа гэж ойлгож байгаа шүү. Үүнийг иргэддээ сайн ойлгуулаарай.

Ер нь бид нар энэ хүний эрх, хувь хүний нууц гэдгийг хадгалах тал дээрээ анхаарах ёстой. Би харин энэ 27.8 дээр асуулт гараад байх юм. Манайх ингэхээрээ л завхардаг юм. Энэ бичлэгийн системийг хууль ёсны дагуу ашиглаж байгаа эсэхэд хяналт тавих зорилгоор хууль хяналтын байгууллагатай хамтран шалгалт хийж болно. Ингээд л нөгөө юм руу давхиад ороод ирдэг. Тэгээд бичлэг хуулж аваад түүнийгээ шал өөр нэрээр өөр газраас тавиад энэ нийгмийг самарч эхэлдэг юм. Энэ дээр та нар сайн яриадахаач дээ.

Дараа нь 27.9 дээр энэ хариуцагч эрх бүхий байгууллага, албан тушаалтан дууны дүрсний, дуу дүрсний бичлэгийн системд байгаа мэдээлэлтэй танилцах, тандаж харах гэдгийг нь хасчхаж байгаа юм байна, тийм ээ. Хадгалагдсан бичлэгийг үзүүлэх, сонсгох, хуулбарлаж өгч болно. Үүнийг маш сайн нарийн зохион байгуулахгүй бол болохгүй.

Дахиад би Энх-Амгалан гишүүнтэй 1 юм дээр санал нэг байгаа. Ер нь энэ хувь хүний нууцад халдаад байгаа этгээдийг байна шүү дээ, энэ санкцыг нь жоохон нэммээр байна шүү дээ. Эрүүгийн хариуцлага хүлээлгэмээр байна шүү дээ. Би одоо ингээд бодохоор энэ 2 хуульд өөрчлөлт ороод байгаа юм. Нөгөө Зөрчлийн тухай хууль. Тэр чинь яахав дээ хэдэн цаасаар торгоно. Одоо ийм хулгай дээрэм хийж байгаа хүмүүс чинь бол мөнгөнд баригдахгүй хүмүүс байгаа шүү дээ. Тэр муу орцны нөхөрт хэдэн төгрөг өгөөд л тэгээд тэр бичлэгийг чинь аваад нийгмийн самраад байгаа юм. Хувь хүний нууцад ингэж халдаад байгаа юм. Тэгэхээр энд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хиймээр байна. Би энэ эрүүгийн хариуцлага хүлээж байгаа, хүлээлгэж байгаа хэсгийг нь жоохон ойлгохгүй байна. Манайхны нэг нь тайлбарлаад өгөөч. Энэ Эрүүгийн нэмэлт, өөрчлөлт оруулах гээд уг нь байна. Юуг нь эрүүгийн хариуцлага хүлээлгээд, юуг нь Зөрчлийн хуулиар хээн төгрөгөөр торгох гээд байгаа юм.

Ер нь бид нар хууль гаргаад хэзээ энэ хууль хэрэгжих вэ гэхээр хууль өөрөө чанга байж л хэрэгжинэ. Ялангуяа хувь хүний нууцтай холбоотой, зориуд зохион байгуулалттай янз бүрийн бичлэг хийгээд энэ нийгмийн самарч байгаа юмнуудыг

бол эрүүгийн хариуцлага хүлээлгэмээр байна. Тэгэхээр өнгөө хүн чинь чамд би 5 сая төгрөг өгье гэхээр би 5 сая төгрөг авах уу, би шоронд суух уу. Ийм сонголт дээр аваачих хэрэгтэй. Тэгэхгүй бол сая төгрөгөөр тэгээд л өгчихнө. Наана чинь амьжиргаа, иргэдийн амьвдар яах вэ хэцүү, юун 5 сая байтугай 500 мянган төгрөггүй байхад энэ мөнгөөр үүнийг бол хамгаалж чадахгүй ээ. Магадгүй бид нар гайгүй нийгэм болоод ирэхийн цагт тэр торгуулийн систем нь ажилладаг болж магадгүй. Одоо бол хэдэн жолооч нэртэй хүмүүсээ л дарамталдаг Зөрчлийн хууль … /минут дуусав/

С.Бямбацогт: Баасандорж дарга хариулъя. 3 дугаар микрофон.

Алтанхуяг гишүүний асуултад хариулъя. Баасандорж. 27.8 дахь хэсгийг асууж байна. 27.3, 27.4-т заасан энэ үйл ажиллагааг нөгөө хууль хяналтын зорилгоор хууль хяналтын байгууллагатай хамтран шалгалт хийж болно гэсэн заалт байгаа. Энэ Алтанхуяг гишүүн ээ, яг энэ хуулийн чухал нэгэн заалт нь байгаа юм аа. Жишээ нь, зөвшөөрсөн, хориглосон заалтыг тухайн утсан дээр эсхүл нөгөө ресторан, караокед яг зөв хэрэглэж байна уу. Жишээ нь ресторанд хоолны газар тусгай өрөөнд буюу вип өрөөнд орчхоод дууны бичлэг хийж байна уу. Зөвхөн дүрсний бичлэг хийж байна уу. Энэ вип өрөөнд бол аль нь ч байхгүй байх ёстой. Нийтийн зааланд дууны бичлэг байхгүй зөвхөн дүрсний бичлэг байх ёстой. Жишээ нь, орц гарц дээр, одоо давхартаа 2 юм уу 3 айл амьдарч байхад яг тэр камерыг бусдад түгээж байна уу үгүй юу. Одоо тэр камерын бичлэгийг зөвхөн хууль хяналтын байгууллагын зөвшөөрлөөр өгнө. Эсхүл тухайн давхарт амьдарч байгаа 2 айл юм уу 3 айлын зөвшөөрөлтэйгөөр л тэр бичлэгийг хариулах ёстой. Бусдад түгээж болохгүй. Тэгэхээр яг энэ хориглосон заалт юм уу ариун цэврийн өрөөнд энэ камерыг яг стандартын дагуу стандартын камер тавьсан байна уу үгүй юу гэдгийг холбогдох хууль хяналтын байгууллагадаа л энэ Хүний эрхийн Үндэсний Комисс маань шалгалт хийе ээ гэж байгаа юм.

Тэгэхээр энэ 27.8 бол байх ёстой заалт болов уу гэж Засгийн газрын зүгээс харж байгаа юм аа.

27.9 бол хуульд заасан журмын дагуу гэдэг нь өөрөө нөгөө эрүүгийн процесстой холбоотой ажиллагаа, нөгөө дууны дүрсний бичлэгийг зөвхөн зөвшөөрлөөр, процесс ажиллагаанд оролцож байгаа субъектүүдэд л зөвшөөрөлтэйгөөр тухайлсан хуулиар зөвшөөрсөн этгээдүүд энэ 27.9 ажиллаж эхлэх юм.

Таны сүүлийн асуусан тэр зөрчил, эрүүгийн хууль дээр холбогдох өөрчлөлтүүд орж байгаа. Жишээ нь, хүний эмзэг мэдээлэл болон хувь хүний нууцад хамаарсан мэдээллүүдийг задруулсан, түгээсэн, дамжуулсан бол Баасандорж эрүүгийн хариуцлага хүлээнэ. Хэрвээ эмзэг болон хувь хүний нууцаас холбоотой өөр мэдээллийг хүний хувийн мэдээллийг бусдад задруулсан байвал тухайн субъект маань зөрчлийн хариуцлага хүлээнэ гээд ялгаж ангилж өгсөн байгаа. Эмзэг мэдээлэл болон хувь хүний нууцтай холбоотой нь эрүүгийн хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь зөрчлийн хариуцлага хүлээхээр дагасан хуулиудад өөрчлөлт оруулсан байгаа.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн гишүүн Сүхбаатар гишүүн хариулъя.

Ж.Сүхбаатар: Алтанхуяг гишүүний асуудал их чухал байгаа юм аа. Бараг олон хүн үүнийг хүлээгээд байгаа юм бол мөн л дөө. Тэгээд яах вэ хойд талд нь

тэр Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гээд дагалдах хуулийн төсөл явж байгаа байх. Түүн дотор бол юу гэж байгаа л даа. Дуу дүрсний асуудлуудад Эрүүгийн хуулийн 13.8, 1, 3, 4 эд нар дээр бол тодотгосон юмнууд явж байгаа. Гэхдээ таны 1 хэлж байгаа асуудал байгаад байгаа. Ялыг нь чангатгамаар байна гэж. Би бол яг энэ дээр яах вэ манайх дагалдуулаад энэ тодруулчихсан ч гэсэн яг ялыг чангатгах асуудал дээр санал орж ирээгүй байгаа л даа. Тэгэхээр үүнийг уг нь Учрал дарга аа, энэ дээр нэг зорчих эрхийг хязгаарлана гэж аягүй жоохон ялтай юм байгаад байгаа юм. Тэгээд яг үнэндээ хэлэхэд бол жоохон хүндрүүлмээр л байгаад байгаа юм. Ялын бодлого энэ дээр бол. Бид нарын юм дээр бол яг тэр Алтанхуяг гишүүний хэлээд байгаа шүүмжлэл бол ялын бодлого нь жоохон суул хэвээрээ, түүнийг нь хөндөөгүй, зүгээр тодотгосон. Ингээд холбогдох юмнуудыг нь нарийвчлаад хийчихсэн юм аа. Энэ санаачилсан хуулийн төслийг дагалдсан юм дотор бол байгаа.

Би бол зүгээр энэ дээр тэр нэг хорих ялынх нь талын юм руу нь жоохон чангаруулмаар л байгаа байхгүй юу. Тэгээд үүнийг одоо яриад санал гаргаад ингээд хийх асуудал дээр юу бах юм. Эрүүгийн хуулийн асуудал чинь Нямбаатар сайд юу гэж үзэх юм. Энэ дээр ялыг нь чангатгамаар л байгаа. Энэ хуулийг ингээд бас онцлоод гаргаж байгаа юм чинь Эрүүгийн хуулийнх нь тэр заалт нь 13 дээр энэ дагалдчихсан хуулийн төсөл нь явж байгаа байхгүй юу. Эрүүгийн хууль. Энэ дээр тэр хорих ял руу нь илүү оруулмаар байгаа юм. Ер нь тэгээд ял өгдөг байж л энэ хувийн мэдээллийг хамгаалахгүй бол Зөрчлийн хуулиар бүтэхгүй л дээ. Тэгээд нэг хэдэн хүн торгуулчхаад хүний хувийн мэдээлэл задалж хаячихаад л. Тэгээд нэг хэдэн цаасаар торгуулчхаад эсвэл Эрүүгийн хуулиар гэхээр нэг тийм зорчих эрх хязгаарлагдсан эсвэл жижигхэн бас торгох ял нийгэмд тустай ажил хийсэн юм уу торгох ялаар ингээд жоохон юм хийчхээд л ингээд мөнгөний асуудал байхгүй юу. Цаана нь хүний амьдралыг сүйтгэж хаячхаад л. Тэгэхээр энэ дээр би бас тийм асуудал байгаа л гэж бодоод байгаа. Тэгээд яг энэ асуудал дээр тийм асуудал байна.

С.Бямбацогт: Асуултад ажлын хэсэг хариулах ёстой. Тэгээд ажлын хэсгийн гишүүн би бол тэгж бодож байна гээд бодлоо яриад байх юм. Ажлын хэсэг яг ярьсан байх ёстой шүү дээ. Чангатгах ёстой бол чангатгах ёстой, чангатгахгүй бол чангатгахгүй гээд үндэслэлээ. Үүнийг та нар юу яа л даа. Учрал гишүүн гүйцэгээд хариулчих. Энэ аягүй чухал асуудал. Чухал асуудлыг нэлээн нухацтай ярьсан байх ёстой. Тэгээд ажлын хэсэг томьёоллоо оруулж ирэх ёстой. Ажлын хэсгийн ахлагч хариулъя.

Н.Учрал: Энэ Эрүүгийн хууль дээр дагаж Эрүүгийн хууль дээр өөрчлөлт орж байгаа. 13.8 буюу зөвшөөрөлгүй гэрэл зураг авах, дуу дүрсний бичлэг хийж дамжуулах, тараах дээр бол Эрүүгийн хуулийн санкц нь тодорхой тохиолдол 451 нэгжээс 2700 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох эсвэл нийтэд тустай ажил хийлгэх эсвэл 1 сараас 6 сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах. 13.10 буюу эрүүл мэнд, захидал харилцааны хөрөнгө, генетик, биометрик, тоон гарын үсгийн хувийн түлхүүр, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа илэрхийлэх, бэлгийн харилцааны мэдээлэлд халдах дээр мөн торгох эсвэл зорчих эрхийг хязгаарлах. 13.11 буюу бас тодорхой тохиолдол буюу хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг задруулсан тохиолдолд мөн нийтэд тустай ажил хийлгэх эсвэл 1 сараас 1 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах. Харин албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн хувь хүний нууцыг задруулсан тохиолдолд мөн торгох эсвэл 1 жилээс 5 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах эсвэл 1 жилээс 5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гэдэг ийм сонгох

санкцтайгаар оруулж ирсэн. Тэгэхээр чангатгана гэхээр зөвхөн хорих ялтай болгоод эхлэх юм бол бас л хүний эрхтэй холбоотой асуудал үүснэ ээ. Тэгэхээр ийм сонгох санкцтайгаар явахгүй бол бас энэ чинь хүний эрхтэй холбоотой асуудал учраас шууд зөвхөн хорих ялаар шийдээд явээд байх юм бол энэ бас зохистой биш ээ гэж үзэж байгаа. Тэгэхээр ийм сонгох санкцтай байх нь зохимжтой гэж ажлын хэсэг үзэж байгаа.

С.Бямбацогт: Алтанхуяг гишүүн тодруулъя. Энэ чинь нөгөө шантаажлаад бичлэгийг нь хийж авчхаад тэгээд шантаажлаад зардаг, дамладаг одоо юу гэдэг юм түүнээс болоод асуудал үүсдэг гэсэн асуудал бас яриад байгаа шүү дээ. Алтанхуяг гишүүн

Н.Алтанхуяг: Би бас ажлын хэсгийн гишүүн л дээ. Би бас дутуу л ажиллаад байгаа юм. Тэгэхээр Учрал гишүүнд би зүгээр ийм санаа хэлье. Хэдүүлээ яг энэ хэсгийг цаашаа жоохон гүйцээгээд боловсруулах дээр ажиллавал яасан юм бэ гэж л санал хэлж байгаа юм би. Ер нь амьдрал дээр үнэхээр шударга бус байдал чинь үүнээс бий болж байгаа байхгүй юу. Энэ мөнгө төгрөггүй нийгэмд чинь бол та нар мөнгө төгрөгөөр хэн нь торгуулдаг юм гэхээр уулаасаа зорилготой нөхөд л торгуулж байгаа юм. Тэр торгуулийг чинь төлөх гэж тэр хуулийг чинь зөрчих гэж ажиллаж байгаа байхгүй юу даа. Тэгэхээр хэдүүлээ энэ дээр жоохон ажиллавал яасан юм. 27.8 дээр би ингээд байгаа юм, Баасандорж дарга аа. Хамтран шалгалт хийж болно гэдэг чинь социалист өгүүлбэр гэж хэлэх гэж байгаа юм. Та нар хууль гаргачхаад түүний хойноос шалгалт хийгээд бүтэхгүй. Хууль гарсан бол хэрэгждэг байх ёстой. Энэ шаблон энэ хүснэгтийн дагуу та нар юу тавьсан, тэр нь ингэнэ. Хуулиар энэ үүнийг бол хаасан. Зөвшөөрөгдсөн ч юм болъё. Тэгээд санкц буюу торгууль шийтгэл чинь эсвэл тэр хорьдог ял чинь өндөр байх ёстой. Тэгэхгүй энд бид нар энд буруу юм хийгээд байна шүү дээ. Нэг юм гаргачхаад л хойноос нь очиж шалгадаг … /минут дуусав/

С.Бямбацогт: Учрал гишүүн хариулъя. Ажлын хэсгийн ахлагч

Н.Учрал: Дууны, дүрсний, дуу дүрсний төхөөрөмж байрлуулахад тавигдах шаардлага гэж шаардлага гарна аа. Энэ шаардлагыг Хүний эрхийн Үндэсний Комисс саналыг нь боловсруулаад одоо энэ хуулиар бол нөгөө цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ шаардлагыг стандартыг боловсруулж тогтооно. Тэгээд стандартыг энэ төрийн захиргааны төв байгууллагыг тогтоосны дараа яг энэ саналыг үндэслээд боловсруулсан энэ стандартыг мөрдөж байна уу. Тэр камер нь тэр дуу дүрсний бичлэгийн төхөөрөмж нь шаардлагад нийцэж байна уу эсэх дээр хяналт тавихгүй бол бас болохгүй байгаа юм. Тэгэхээр таны Алтанхуяг гишүүний яриад байгаа тэр Хүний эрхийн Үндэсний Комиссын зүгээс үүн дээр хяналт тавихгүй бол болохгүй. Тэгэхдээ үүнийг Хүний эрхийн Үндэсний Комисс дангаараа яваад энэ шалгалтыг хийгээд явахаасаа илүү … /минут дуусав/

С.Бямбацогт: Энх-Амгалан гишүүн асуултаа асууя.

Б.Энх-Амгалан: Энэ 27.4.1 энэ ариун цэврийн өрөө, хувцас солих өрөө, караоке, зочид буудлын өрөө энэ эмнэлгийн хэвтэн эмчлүүлэх өрөө энэ тэр гээд ордог байж. Нөгөө саун, массаж, эмчилгээний өрөө орох уу. Энэ дотроо оруулбал яадаг юм. Байж байх юм уу эсвэл.

2 дахь асуудал. Би асууж байгаа шүү. Энэ гэрэл зураг аваад билэг хийгээд л тараагаад л энэ генетик геометрийн мэдээллүүдийг ингээд тараагаад санаатайгаар зорилготойгоор хийчхээд тэгээд түүний дараа нэг торгуулаад л эсвэл нэг нийгэмд тустай ажил хийгээд л эсвэл зорчих эрхийг хязгаарлуулаад л ингээд л болчихдог юм бол наад хүмүүс чинь үүнийг чинь дуртайяа хийлгэнэ шүү дээ. 5 цаасаар торгуулаад л тэгээд гүтгэчихье, тэгээд л бичлэгийг нь хийчихье, сууж байгаа газар нь ширээн доогуур нь бичлэг хийж байгаад гаргаад нийгэмд цацчихъя, ингэчихье гээд л ингээд яваад байдаг. Үүнийгээ жоохон нэгэнт хувь хүний мэдээллийн аюулгүй байдалтай холбоотой асуудал ярьж байгаа бол хувь хүний аюулгүй байдалтай холбоотой асуудал ярьж байгаа бол үүнийг жоохон чангатгавал яадаг юм бэ. ажлын хэсгийнхэн. Үүнийг нэг анхааараач.

Дуу дүрсний бичлэгийн системд тавигдах энэ шаардлагыг Хүний эрхийн Үндэсний Комисс тодорхойлно гэж одоо ямар юм байдаг юм бэ. Энэ бол мэдээллийг харилцаа холбоо хариуцсан төрийн захиргааны байгууллага стандартыг тогтооно биз. Хүний эрхийн Комисс ийм юм тогтоож чадахгүй байх аа. Үүнийг бас анхааралдаа авах хэрэгтэй байх.

Энэ мэдээлэл хариуцагч байгууллагаас эрх бүхий байгууллага, албан тушаалтан энэ дуу дүрсний болон дуу, дүрсний бичлэгийг хуулбарлан авч болно оо гэж ийм заалт 27.9 дээр байж байгаа юм. Энэ одоо албан тушаалтан гэдэг нь ямар хүн байдаг юм бэ. Хуулийн байгууллагын албан тушаалтныг хэлээд байгаа юм уу эсвэл эрх дарх бүхий дарга цэргийг хэлээд байгаа юм уу. Үүнийг тодорхойлж өгөөч. Ийм 3 асуултад хариулт авъя.

С.Бямбацогт: Учрал гишүүн асуултад хариулъя.

Н.Учрал: Хүний эрхтэй холбоотой олон улсын гэрээ конвенцод нэгдсэн үүргээ биелүүлэх ёстой. Сүүлийн үед бид нар бас Хүний эрхийн дэд хороон дээр хүртэл ярьж байгаа. Тэгэхээр Хүний эрхийн Үндэсний Комисс бол тэр дуу бичлэг, дууны, дүрсний төхөөрөмжийг хаана байршуулах ёстой юм, хүний эрхийг яаж хамгаалах юм гэдэг дээр саналыг бол боловсруулах нь зөв юм байна лээ. Тэгэхээр энэ саналыг боловсруулаад харин төрийн захиргааны төв байгууллага нь үүн дээр тэр шаардлагатай холбогдуулаад журмаа боловсруулна.

27.4.1 дээр нийтийн үйлчилгээний газрын тусгай зориулалтын үйлчилгээний өрөө, караоке, зочид буудлын өрөө гэвэл мөн хүний халдашгүй чөлөөтэй байх эрхэд илтэд халдахаар байршил гэж ерөнхий байдлаар бас энэ дүрс бичлэгийн төхөөрөмж байршуулахыг хориглож байгаа дээр нэмж өгсөн. Нэг ёсондоо бол хүний чөлөөтэй байх эрхэд илтэд халдахаар байршил гэдэг дээр ерөнхий байдлаар зохицуулж өгсөн учраас энэ дээр бол шууд хамрагдаад явна аа.

Гишүүдийн хэлж байгаа тэр санкцыг илүү бас чангатгах дээр анхааараач ээ гэж. Үүн дээр бас Байнгын хорооны даргаас бас чиглэл аваад эцсийн хэлэлцүүлэг дээр анхааръя. Гэхдээ тэр хүнийг гүтгэх, доромжлох асуудал бол тэр Эрүүгийнхээ хууль тогтоомжоор зохицуулагдаад явж байгаа шүү дээ. Тэгэхээр яг энэ дээр бол хүний гүтгэхтэй холбогдуулаад тэр бол тусгай санкцтай учраас зохицуулагдаад явна.

Харин тэр хүний эмзэг мэдээлэл, хүний хувийн мэдээллийг түгээх, задлах асуудал бол дан ганц торгоод зорчих эрхийг хязгаарлаад биш хорих ял бол сонголттой байгаа.

С.Бямбацогт: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Сая бас гишүүдийн хөндөж байгаа бүгдээрээ л ажлын хэсгийн гишүүд. Сүхбаатар гишүүн, Алтанхуяг гишүүн энэ дуу дүрсний бичлэг хийгээд хууль бусаар хийгээд тийм үү, үүнийг олон нийтэд задруулах, олон нийтэд задруулна шүү гэж шантаажлах, тэгээд торгуулаад салдаг эсхүл шантаажилж байгаад мөнгө төгрөг нэхдэг иймэрхүү асуудлуудыг нэлээн газар авч байгаа. Үүнийг цэгцлэх ёстой. Үүнт эй холбоотой хариуцлагын тэр заалтуудыг нэлээн чангатгах тал дээр санал хэлж байна шүү. Манай ажлын хэсгийн гишүүд бас анхааараад ажиллачхаарай.

Ажлын хэсгийн гишүүд үүнийг эцсийн хэлэлцүүлэг дээр анхаарч нэлээн чангатгах тал дээр анхааараарай гэдгийг чиглэл болгоё.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Төслийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсгийн “дүрс бичлэгийн” гэснийг, 27.9 дэх хэсгийн “хандаж харах,” гэснийг болон 27.11 дэх хэсгийг тус тус хасч, 27.4.3 дахь заалтын “нийтийн болон орон сууцны” гэсний дараа “орох, гарах нийтийн хэсэг болон дундын эзэмшлийн талбайн” гэж нэмж, 27.4.1 дэх заалтын “караоке” гэснийг “караокены өрөө,” гэж, 27.4.3 дахь заалтын “дүрст хэлбэрээр түгээх” гэснийг “дүрст хэлбэрээр тараах” гэж, 27.7 дахь хэсгийн “бичлэгийн системд” гэснийг “бичлэгийн төхөөрөмж байршуулахад” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 27.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 27.2 дахь хэсэг болгох:

“27.2. Дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн систем нь энэ хуулийн 27.1-д заасан төхөөрөмж, мэдээлэл дамжуулах сүлжээ, хадгалах төхөөрөмж, программ хангамжаас бүрдэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт 68,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гишүүдээс сая 27 дугаар зүйл дээр бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 28 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гаргаагүй байна. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдийн бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 29 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна.

Ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй 1 санал байна.

Төслийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

75 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 30 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гаргаагүй байна. Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 31 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гаргаагүй байна. Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 32 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна.

Ажлын хэсгээс 2 саналтай байна. Дагаж мөрдөх хугацаатай холбоотой юм байна.

Төслийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийн “2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс” гэснийг “2022 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Энэ санал хураалтыг цуцалъя. Хууль санаачлагч, Засгийн газар. Хууль зүй, дотоод хэргийн сайд Нямбаатар саналаа хэлье. Хуулийг хэрэгжүүлэх учраас.

Х.Нямбаатар: Энэ цахимын 4 хууль ирэх онд гарцаа байхгүй хэрэгжиж эхэлнэ ээ. Гэхдээ зүгээр яг энэ хуулийн хэрэгжих хугацааг ирэх оны 5 дугаар сарын 01 гэж өөрчилж санал хураалгах хүсэлтэй байгаа. Яагаад гэвэл энэ хууль хэрэгжихэд бас хийгдэх бэлтгэл ажлууд байгаа. Яагаад гэвэл энэ дандаа нөгөө хувь хүнд нотепикейшн очдог мэдээллийн системд ийм тохируулгууд хийх шаардлагатай. 3 сая 300 мянган иргэн түүний насанд хүрсэн 2,5 сая иргэнтэй холбоотой төрд хадгалагдаж байгаа бүх мэдээлэлд төрийн захиргааны байгууллага, албан тушаалтнаас танилцаж байгаа тохиолдол бүр тухайн иргэнд мэдээлэл байдлаар очдог ийм тохиргоо хийгдэх шаардлагууд байгаа.

Тоон гарын үсгийн хуулийг бол бид нар 3 сарын 01-нээс хэрэгжүүлье гээд зөвшөөрчихсөн. Яагаад гэвэл энэ бол улсын бүртгэлийн байгууллага өөрсдөө захиргааны журмаар хийгдэх ажил. Тоон гарын үсэгтэй уялдаад энэ хууль хэрэгжихэд бас тодорхой хугацаа шаардлагатай байгаа учраас үүнийг 5 сарын 01 гэж ийм хууль хэрэгжих хугацааг өөрчлөх саналтай байна.

Нийтийн мэдээлэл энэ 2 бол яг адилхан шүү дээ. Нийтийн мэдээлэл, хувь хүний мэдээлэл хамгаалах 2. Хоёулаа 5 сарын 01.

Өмнөх дэд бүтцийн угсралтаа бол бид нар 3 сарын 01 гэхэд хийж дуусна. Дэд бүтцийн угсралт дээрээ үндэслээд дараагийн тохиргоонуудаа бид нар 2 сарын хугацаанд хийнэ ээ л гэсэн ийм тооцоотой байна.

С.Бямбацогт: Ажлын хэсгээс Нямбаатар гишүүний саналыг зөвшөөрч байна. Тийм болохоор саяын саналын томьёоллыг дахиж уншиж танилцуулъя.

Төслийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийн “2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс” гэснийг “2022 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

60 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Дараагийн санал хураалт.

Төслийн талаарх саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, бүлэг, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

73,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гишүүдээс гарсан санал байхгүй байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс бэлтгэсэн найруулгын саналаар санал хураалт явуулъя. 3 санал байна.

1.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.6 дахь заалтын “хөндөөгүй тохиолдолд” гэснийг “хөндөхгүйгээр” гэж, төслийн “дүрс бичлэг” гэснийг “дүрсний бичлэг” гэж тохиолдол бүрд агуулгад нь тохируулан тус тус өөрчлөх.

2.Төслийн 23 дугаар зүйлийн 23.1.1 дэх заалтын “мэдээлэлд хүний оролцоогүй цахим хэлбэрээр хийх боловсруулалт нь” гэснийг хасах.

3.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтыг доор дурдсанаар 5.1.1, 5.1.2 дахь заалт болгох:

“5.1.1. хүний эрх, эрх чөлөөг зөрчихгүй байх;
5.1.2. хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;” Ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Найруулгын санал.

73,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Ажлын хэсэг дээр тухайн зүйл дээр санал гаргаагүй байна. Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсэг дээр тухайн зүйл дээр санал гаргаагүй байна. Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсгээс 1 санал байна. Ажлын хэсгийн саналыг уншиж танилцуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн “12.1, 12.3 дахь хэсгийн “Хувь хүний нууцын тухай” гэснийг “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай” гэж,” гэснийг “12.1 дэх хэсгийн “хувь хүний нууцад хамаарах бөгөөд түүнтэй холбогдох асуудлыг Хувь хүний нууцын тухай” гэснийг “хүний хувийн мэдээлэлд хамаарах бөгөөд түүнтэй холбогдох асуудлыг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай” гэж, 12.3 дахь хэсгийн “Хувь хүний нууцын тухай” гэснийг “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай” гэж” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

66,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хуулийн төсөлтэй холбоотой гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсэг тухайн зүйл санал гаргаагүй байна. гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсэг тухайн зүйл дээр санал гаргаагүй байна. Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Байхгүй байна. Ажлын хэсэг тухайн зүйл дээр санал гаргаагүй байна. Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсэг тухайн зүйл дээр санал гаргаагүй байна. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдээс бичгээр гаргасан санал алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсэг тухайн зүйл дээр санал гаргаагүй байна. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Байгууллагын нууцын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Байгууллагын нууцын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алтанхуяг гишүүн.

Н.Алтанхуяг: Нямбаатар сайдыг байсан дээр би юм асуух гээд байна л даа. Нямбаатар сайд аа. Одоо хэдүүлээ ингээд энэ нийтийн мэдээлэл буюу одоо иргэд мэдээлэл олж авах эрхийн тухай хууль. Энэ хувийн мэдээлэлтэй холбоотой хууль. Олон хуулиуд ингээд батлагдаад гарах нь. Тэгэхээр нөгөө талд нь нэг ийм хадны мангаа шиг хууль байгаа юм. Байгууллагын нууц, гүйцэтгэх ажлын нууц гээд баахан юм нуацалсан. Нуацлах нуацлахдаа байгууллагын даргын үзэмжээр нуацалдаг ийм хуулиуд байгаад байгаа юм аа. Үүнийг ер нь Засгийн газар хэзээ оруулж ирж өөрчлүүлье гэж бодож байгаа юм бэ. Бид нар маш гоё хууль баталдаг. Нөгөө талд нь нөгөө дарга нар дур зоргоороо нууц болгох ийм юм хэвээрээ байгаа учраас энэ бид нарын батлагдсан хуулийн үр дүн гарахад бас удах болов уу гэж би санаа зовоод байна. Энэ дээр хариулт хэрэгтэй байна.

С.Бямбацогт: Нямбаатар сайд хариулъя.

Х.Нямбаатар: Баярлалаа. Алтанхуяг гишүүний асуултад маш товчхон хариулъя. 1 дүгээрт бид Нийтийн мэдээллийн тухай хуулиар тэр байгууллагуудын өөрсдийнх нь нуацлаад байдаг тэр 57 багц мэдээллийг энэ Нийтийн мэдээллийн хуулиар ил болгож өгч байгаа юм. Өөрөөр хэлбэл тэр лиценз, ашигт малтмалын лиценз, газрын зөвшөөрөл бусад тусгай тусгай зөвшөөрөлтэй холбоотой. Нэн ялангуяа ийм ашиг сонирхол дагуулдаг бүх мэдээллүүдийг Нийтийн мэдээллийн тухай хуулиар ил болгох үүргийг тэр нуацалдаг байгууллагуудад үүрэгжүүлж өгч байгаа юм.

2 дугаарт, Байгууллагын нуацын тухай хууль, Төрийн болон албаны нуацын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг энэ ондоо багтаж яамдаас санал авч өргөн барихаар явж байгаа. Энэ ондоо багтаж. Ингээд энэ хуулиуд хамтдаа цуг хэрэгжиж эхэлнэ.

Ер нь бид нарын гол барьж байгаа зарчим тэр байгууллага өөр дээрээ нууц гэдэг тамга, тэмдэг дарж өөр дээрээ нууцлал үүсгэдэг, жагсаалт үүсгэдэг явдлыг л больё оо л гэж байгаа юм. Гарцаа байхгүй тэр Үндэсний аюулгүй байдалтай холбоотой нууцтай холбоотой асуудлыг л нуцынх нь түвшинд хадгалъя. Бусад зүйлийг нь ил болгоё оо.

Ерөнхий сайдаас бас чиглэл өгсөн. Засгийн газрын хуралдааныг хаалттай явуулдаг энэ тохиолдлыг бүр багасгаач аа. Гарцаа байхгүй Үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудал дээр л хаалттай хуралдъя. Бусад бүх Засгийн газрын хуралдаануудыг ил явуулдаг болъё гэдэг ийм чиглэл өгөөд бас давхар ажиллаж байгаа.

С.Бямбацогт: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Ажлын хэсгээс санал гаргаагүй байна. Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Байхгүй байна. Ажлын хэсгээс санал гаргаагүй. Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Байгууллагын нуцын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсгээс бэлдсэн зарчмын зөрүүтэй 2 санал байна. Санал хураалт явуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн “Гаалийн тухай хуулийн” гэсний дараа “5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсгийн “төр, хувь хүний, байгууллагын нуцад хамаарах мэдээллийг” гэснийг “төрийн болон албаны, байгууллагын нууц, хүний хувийн мэдээллийг” гэж, “нуцын хууль тогтоомжоор” гэснийг “холбогдох хууль тогтоомжоор” гэж,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

60 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Төслийн 1 дүгээр зүйлийн “хүний эмзэг мэдээллийг” гэснийг “хүний хувийн мэдээллийг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

60 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсгээс санал гараагүй. Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Гамшгаас хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Гамшгаас хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсгээс санал гаргаагүй байна. Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Ажлын хэсгээс тухай зүйл дээр санал гаргаагүй байна. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Гамшгаас хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гаргаагүй байна. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гаргаагүй байна. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гаргаагүй. Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гаргаагүй. Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Жендэрийн эрх, тэгш байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Жендэрийн эрх, тэгш байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гараагүй байна. Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гараагүй. Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Жендэрийн эрх, тэгш байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Захиргааны ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Захиргааны ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гаргаагүй байна. Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гаргаагүй байна. Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Захиргааны ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсгээс бэлдсэн зарчмын зөрүүтэй санал байгаа юм байна. Санал хураалт явуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн 101 дүгээр зүйлийн 101.2 дахь хэсгийн “төр, байгууллага, хувь хүний нууцтай” гэснийг “төрийн болон албаны, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлтэй” гэж” гэсний дараа “, “Захидал харилцааны нууцыг” гэснийг “Захидал харилцааны мэдээллийг” гэж” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

73,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гаргаагүй байна. Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Ажлын хэсгээс 5 санал байгаа юм байна. Санал хураалт явуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 6.22 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийн “дүрсний, дуу-дүрсний” гэсний өмнө “дууны,” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

66 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 6.22 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “орон байранд” гэснийг “нийтийн зориулалттай орон сууцанд оршин сууж байгаа” гэж, 1 дэх заалтын Тайлбар хэсгийн “караоке” гэснийг “караокены өрөө,” гэж, 2 дахь заалтын 6.27 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “мэдээллийн эзний эрх, эрх чөлөөг хөндөж” гэснийг “мэдээллийн эзний эрх, эрх чөлөөг зөрчиж,” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

66 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 6.22 дугаар зүйлийн Тайлбар хэсгийн “цахилгаан шат” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Цахим бодлогын байнгын хорооны гишүүд хаачсан бэ. Ганцхан Батшугар гишүүн сууж байна. Бусад нь манай Хууль зүйн байнгын хорооны гишүүд сууж байна шүү. Нөхөд өө.

Санал хураалт 60 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Инновац, цахим бодлогын байнгын хорооны ажлын алба гишүүдээ дуудаарай.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 6.27 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

53,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

5. Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх:

“2 дугаар зүйл.Энэ хуулийг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

66,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гишүүдээс бичгээр гаргасан саналууд байхгүй байна.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гаргаагүй. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гаргаагүй. Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсэг дээр тухайн зүйл дээр санал гаргаагүй. Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зээлийн мэдээллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Зээлийн мэдээллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гараагүй байна. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гаргаагүй. Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй учир санал хураалт байхгүй.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зээлийн мэдээллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Инновацын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Инновацын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсэг болон гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсэг болон гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Инновацын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй 1 саналаар санал бэлдсэн байна. Санал хураалт явуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн “38 дугаар зүйлийн 38.6 дахь хэсэг, 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг,” гэснийг “38 дугаар зүйлийн 38.6 дахь хэсгийн “төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой” гэснийг “төрийн болон албаны, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлтэй холбоотой” гэж, 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийн “төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотойгоос” гэснийг “төрийн болон албаны, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлтэй холбоотойгоос” гэж,” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

80 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна. Ажлын хэсэг болон гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. Ажлын хэсэг болон гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. Ажлын хэсэг болон гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

